Журмын 5 дугаар хавсралт

# ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

**2023 оны 12 дугаар сарын 11-ны өдөр**

| **Шийдвэрийн дэс дугаар** | **Зүйл, заалтын дэс дугаар** | **Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга** | **Биелэлт** | **Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)** | **Тасарсан болон удаашираа байгаа шалтгаан** |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Нэг. Монгол Улсын Хууль** | | | | | |
| 1. | 1. | **Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай**<br>2023 оны 05 сарын 04 өдөр<br>10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын ИТХ, Засаг даргын Тамгын газар болон бусад төрийн байгууллагын “Ес зүйн зөвлөл”-үүд үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж, шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг зохион байгуулсан. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засаг даргын Тамгын газар “Төрийн албаны харилцааны ур чадвар” сэдэвт сургалт 1, ЕБС “Залуу багш нарт ёс зүйн” сургалт 1, 1-р цэцэрлэг “Багшийн ёс зүй” сургалт 1, Эрүүл мэндийн төв нь “Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй” сургалт 1, нийт 4 сургалтад 132 албан хаагч хамрагдсан. 2023 онд ажлын хариуцлага алдсан 8 албан хаагчид сануулах болон цалин бууруулах арга хэмжээ тооцсон байна. | Хэрэгжих шатандаа 70% | |
| 2. | 2. | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай<br>**2022 оны 07 сарын 05 өдөр**<br>35.1.Согтууруулах ундааны эргэлтэд дараах байгууллага, албан тушаалтан хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд хяналт тавина:<br>35.1.1.хүнсний асуудал эрхэлсэн төрийн | Сумын ЗДТГазар, ГХУСАЗСалбар зөвлөлтэй хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй 36 дэлгүүрт хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай шинэчилсэн хуулийн талаар мэдээлэл хүргэж ажилласан. Мөн насанд хүрээгүй хүүхдэд согтууруулах ундаагаар үйлчлэхгүй байх, үйлчилсэн | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | захиргааны төв байгууллага;<br>35.1.2.бүх шатны Засаг дарга, чөлөөт бүсийн захирагч;<br>35.1.3.татварын байгууллага; | тохиолдолд хүлээх хуулийн хариуцлагын талаарх гарын авлагыг бэлтгэн бүх дэлгүүрүүдэд тараасан. Хяналт шалгалтын явцад зөрчил гаргасан 2 дэлгүүрт Цагдаагийн тасгаас арга хэмжээ тооцсон. | | |
| 3. | 3. | **Төрийн хэмнэлтийн тухай**<br>2022 оны 04 сарын 29 өдөр<br>6.2.Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно. | Төрийн өмчийн автомашинуудыг Засаг даргын Тамгын газрын дэргэд төвлөрүүлж, зайлшгүй шаардлага гарсан нөхцөлд зөвшөөрлөөр ашиглаж байгаа ба сумын Засаг даргаас бусад албан хаагчид суудлын автомашин ашиглаагүй төрийн хэмнэлтийг хэрэгжүүлж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 4. | 11.1.Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй. | Төрийн албаны тухай хуулийн дагуу тэтгэвэрт гарсан 3 албан хаагчид нэг удаагийн мөнгөн тэтгэмж 62,6 сая төгрөг олгосон, өөр урамшуулал давхардуулан олгоогүй. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 5. | 13.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална:<br>13.1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;<br>13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;<br>13.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргахгүй байх;<br>13.1.6.улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга | Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтлан ажилласан.<br>13.1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн хэмнэлтийг зарцуулаагүй.<br>13.1.4. 2023 онд төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй болсон 2 дугаар багийг өндөр хүчдэлд холбох, тог татах үлдэгдэл, Хөл бөмбөгийн талбайтай болох, Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болох зэрэг ажлуудын батлагдсан төсөв барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдлээс шалтгаалж хэрэгжээгүй, үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хийж 2024 онд шилжих хөрөнгө оруулалтаар шаардлагатай төсвийг нэмж батлуулахаар өргөн барьсан. Тус ажлуудыг хүчингүй болгож, гэрээ байгуулах шийдвэр гаргаагүй.<br>13.1.5.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хуулиар | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх;<br>13.1.7.хөдөө аж ахуй, хүнс, импортыг орлох хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд эрэмбэлэх. | батлагдсанаас хойш түүний төсөвт өртөг нэмэгдүүлэх үр дагавар бүхий нэмэлт шаардлагыг зохиогч, ашиглагч, захиалагчийн хяналт тавих этгээд гаргаагүй.<br>13.1.6.улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргаагүй.<br>13.1.7.хөдөө аж ахуй, хүнс, импортыг орлох хөрөнгө оруулалтын ажлуудыг нэн тэргүүнд эрэмбэлж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан. | | |
| | 6. | 13.5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлнэ. | 13.5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр зөвхөн орон нутгийн иргэдийн санал авсан, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан холбогдох зөвшөөрөл олгогдсон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөвт тусгаж санхүүжүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 4. | 7. | **Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай**<br>2021 оны 12 сарын 17 өдөр<br>8.1.Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.<br>8.8.Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.<br>8.9.Хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д | Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар /bat-ulzii.ov.gov.mn/ цахим хуудсанд үйл ажиллагааны мэдээлэл, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээний мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. Мөн ЗДТГ-ын пэйж хуудас, мэдээллийн самбар, мэдээлэл урсдаг самбараар дамжуулан иргэдэд мэдээллийг тогтмол хүргэж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | заасан тайлан, мэдээ, үр дүн, статистик мэдээллийг улирал, хагас жил, жилээр гаргах бөгөөд дараагийн улирал, хагас жил, жилийн эхний сард багтаан цахим хуудсандаа байршуулна. | | | |
| 5. | 8. | Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ 2021 оны 07 сарын 02 өдөр<br>48.1.Ажил олгогч хөдөлмөрийн гэрээг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурах бөгөөд гэрээний нэг хувийг ажилтанд өгөх үүрэгтэй<br>122.1.Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.<br>122.2.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журмыг шинээр баталсан, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд нийт ажилтанд танилцуулж, харагдахуйц газар байршуулах үүрэгтэй. Хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болон хөдөлмөрийн сахилгын зөрчлийг хөдөлмөрийн дотоод журамд тусгайлан заана. | 2022 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс мөрдөж эхэлсэн Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн онцлог заалт, шторк, подкаст, гарын авлага зэргийг сумын нэгдсэн грүпп, Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар сурталчлан ажилласан. Ажил олгогч, ажилтнуудтайгаа Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж, баталгаажуулсан. Хөдөлмөрийн гэрээтэй холбоотой маргаан, гомдол гараагүй.<br>Шинэчилсэн хуульд нийцүүлэн төсөвт байгууллагууд дотоод журмаа шинэчлэн баталж, ажилтнууддаа танилцуулж баталгаажуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 6. | 9. | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/<br>2020.05.07 Дугаар 2020.07.01<br>17.4. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг Засаг даргыг томилогдсоны дараах 90 хоногт багтаан батална. | ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 3/13 дугаар тогтоолоор Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөр нь 5 зорилт бүхий 113 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэн ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 10. | 17.5. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тухайн шатны Засаг дарга батлан хэрэгжүүлнэ. | 2020-2024 оны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Засаг даргаар батлуулж, 2023 онд 64 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийн явцыг 2023 оны 12 дугаар сарын 18-нд сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөсөн. | Хэрэгжих шатандаа 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7. | 11. | Татварын ерөнхий хууль<br>2019-03-22 Дугаар 2020.01.01<br>8.1.Татварын хувь, хэмжээг Улсын Их Хурал, түүний эрх олгосноор Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хууль тогтоомжийн дагуу тус тус тогтооно. | Сумын ИТХурлаар дараах төрлийн татварын хувь хэмжээг тогтоосон. Үүнд: Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 4/19 дүгээр тогтоолоор Бат-Өлзий сумын малчин, мал бүхий этгээдээс адууг 1000 төгрөг, үхрийг 800 төгрөг, хонийг 500 төгрөг, ямааг 1500 төгрөг байхаар албан татварын хувь хэмжээг тогтоосон.<br>Мөн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 6/08 дугаар тогтоолоор Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэгдүгээр хавсралтаар, энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, мөрдөн ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 8. | 12. | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01<br>55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг төрийн байгууллагууд хэрэгжүүлэн, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилгоор үр дүнтэй ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна. Тайлант онд төрийн албан хаагчийн албан томилолтын зардалд 38 хүнд 21,337,6 мянган төгрөг, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллын зардалд 243 хүнд 159,915,5 мянган төгрөг тус тус зарцуулсан. Ажиллах нөхцөлийг сайжруулах чиглэлээр дутагдалтай байсан ажлын техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан.<br>ИТХ, ЗДТГ хамтран Улаанбаатар хот Нутгийн удирдлагын сургалтад байгууллагын зардлаар 11 албан хаагчийг, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч өөрийн зардлаар хамрагдаж төгссөн. 2023 оны 11-р сараас Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад ИТХ-ын мэргэжилтэн хамрагдаж, цаг үеийн эрэлт хэрэгцээ шаардлага, мэргэжлийн сургалт, байгууллагын дотоод сурталтад давхардсан тоогоор 533 албан хаагч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 9. | 13. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016.12.22/ 2017.02.01<br>18.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих;<br>(18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | сэргийлэх хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан. Сумын хэмжээнд хөтөлбөрийг хяналтад авч мөрдөн ажиллаж байна. | | |
| | 14. | 18.1.2.Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх;<br>(18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар ажиллаж, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатанд илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн үйлчилгээг үзүүлэхэд хөрөнгө мөнгөний асуудал зайлшгүй тулгардаг. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг төсөвлөн Төсвийн тухай хуулийн 8.5.1, 8.5.3-т заасан хугацаанд тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлнэ гэж заасны дагуу сумын ИТХурал 500,0 мянган төгрөг төсөвлөж, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 15. | 18.1.3.Хүн амын тоо, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг харгалзан орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах;<br>(18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Бат-Өлзий сум нь түр хамгаалах байртай. Жил бүр засвар, шинэчлэлийн ажлыг шат дараатай шийдвэрлэн ажилладаг. 2023 онд аймгийн ГБХЗХГазарт хүсэлт уламжлан 3,000,000 төгрөгийн дэмжлэг авч түр хамгаалах байрны дотор тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 16. | 19.1.1.Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 сарын 23-ны 13/06 дугаар тогтоолоор гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх сумын Хамтарсан багийн 2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх магадлалтай 12 иргэний судалдгааг гаргаж тухайн өрхүүдээр хамтарсан багийн гишүүд айлчлан нөхцөл байдалтай танилцаж хүүхэддээ тавих хараа хяналтыг сайжруулах, хүүхэд хүмүүжүүлэх | Хэрэгжих шатанд 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | эерэг аргад суралцах, архины хор хөнөөл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, дахин үйлдвэл хуулийн ямар хариуцлага хүлээлгэдэг талаар тайлбарлаж, гэр бүлийн харилцааны талаар зөвлөгөө мэдээлэл өгч, гэр бүлд нь хяналт тавин ажиллаж байна. 2023 онд гэр бүлийн хүчирхийллийн 8 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хүчирхийлэлд өртөгч 10 иргэнийг хамгаалах байранд дуудан авчиран халуун дулаан, тав тухтай орчин бүрдүүлэн тэдэнд тулгараад байгаа асуудлын талаар чөлөөтэй ярилцаж гэр бүлийн тогтвортой байдал, харилцаа хандлага, хүүхдийн эрх, хамгааллын талаар сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөөг 3 удаа өгч ажилласан. | | |
| | 17. | 19.1.2.Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Сумын хамтарсан баг нь Засаг даргаар ахлуулсан 13 хүний бүрэлдэхүүнтэй, ажиллах нөхцөл боломжоор хангагдан тогтвор суурьшилтай, идэвхтэй ажилладаг. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 18. | 19.1.4.Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, хөтөлбөрийн хүрээнд холбогдох судалгаа, мэдээллийн сантай болсон. “Гэр бүлийн үнэ цэн”, “Хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг арга”, Гэр бүлийн харилцаа хандлага, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, хэлэлцүүлгийг 4 удаа зохион байгуулан 200-аа эцэг, эхийг хамруулсан. Мөн гэр бүл төлөвлөлт, тогтвортой гэр бүл, гэр бүлийн эерэг харилцаа, архидалтын хор уршиг, хүүхдээ хэрхэн хүмүүжүүлэх, хүүхэддээ тавих хараа хяналтыг сайжруулах зорилгоор “Гэр бүлийн үнэ цэн” уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан видео бэлтгэн олон нийтийн сүлжээгээр цацаж 6959 хүнд хүрээд байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 19. | 19.1.5.Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх | Үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлын тооцооллыг гарган 2023 оны төсөвт суулгуулах саналыг өгч, 500,0 мянган төгрөг батлуулж, Хамтарсан багийн үйл ажиллагаанд зарцуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | |
| | 20. | 19.1.6.Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг “Үжин” төвийн тэргүүн Ундраа 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр суманд ирж хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн сургалтыг зохион байгуулж 168 эцэг, эх, иргэн хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, гэр бүлийн харилцаа, эрүүл зөв амьдралын дадалд суралцах, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын талаар иргэд мэдээлэлтэй болсон. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Төвхөнбаярыг урин авчирч гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тогтвортой гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, угийн бичиг бичихийн ач тус сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 96 иргэн хамрагдсан. 2023 онд хохирогч 5 иргэнийг Хамгаалах байрандаа хүлээн авч, шаардлагатай үйлчилгээг үзүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 21. | 19.1.8.Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах;<br>(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | 2023 онд охидыг бэлгийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭМТөвөөс 3 удаагийн сургалт зохион байгуулж 110 охин, 100 гаруй эцэг, эхийг хамруулсан. Хууль тогтоомжтой холбогдуулан гарсан танилцуулга мэдээллийг цахимаар өгч 896 иргэнд хүрсэн. Насанд хүрээгүй хүнийг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол оногдуулах ял шийтгэлийн хууль тогтоомжийг цахимаар 450 иргэнд хүргэсэн байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| Хэсгийн дундаж: 95.7 хувь | | | | | |
| **Хоёр. Монгол Улсын Их Хурлын тогтоол** | | | | | |
| 10. | 22. | Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022 оны 06 сарын 17 өдөр дугаар 36<br>2. к/Монгол Улсад үйлдвэрлэсэн брэнд бүтээгдэхүүнийг олон улсын болон бүс нутгийн хэмжээний үзэсгэлэн худалдаанд танилцуулах, сурталчлах боломжийг бүрдүүлж, экспортлох эрх зүйн орчныг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх; | Бат-Өлзий суманд “Алтан намар 2023” үзэсгэлэн худалдааг 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулан 18 иргэн, 2 аж ахуйн нэгж, 3 хоршоо нийт 23 иргэн хүнс, төмс, хүнсний ногоо, гар урлал, цагаан идээний 135 төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 6,422,000 төгрөгийн борлуулалтыг хийсэн. Өвөрхангай аймагт 2023 оны 10 дугаар сарын 1-4-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Өв түншлэл намрын баяр 2023” үзэсгэлэн | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | худалдаанд 2 хоршоо, 2 иргэн 26 төрлийн бүтээгдэхүүнээр оролцон 4,6 сая төгрөгийн борлуулалт хийж оролцсон. /Үүнд: Зөгийн бал, эмийн ургамал, сүү цагаан идээ, төмс/<br>Суманд үйлдвэрлэл эрхэлж байгаа 7 иргэний бүтээгдэхүүнийг олон нийтэд цахимаар сурталчлахаар бүтээгдэхүүний зураг, бичлэг хийн сумын зарын группд байршуулсан | | |
| | 23. | 3. л/"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааны хүрээнд аймгийн төвд 30 гектар, сумын төвд 10 гектар агро ойн аж ахуйг тус тус байгуулах, жимс, жимсгэнийн суулгац үржүүлгийн төв, цэцэрлэгийн аж ахуйг хөгжүүлэх, тариалангийн талбайг хашаажуулж ойн зурвас байгуулах; | Сумын хэмжээнд агро ойн аж ахуйг дэмжин 2 га газарт 2500 ширхэг чацаргана буюу жимс, жимсгэнийн мод тарьсан. Сум дундын Ойн ангид 5 га, 1 аж ахуйн нэгжид 3 га, 3 иргэнд 1 га- мод үржүүлгийн газрын асуудлыг шийдвэрлэж, тарьц суулгацын нөөцтэй болсон. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 24. | 4. а/бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын эрүүл мэндийг хамгаалах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг чанаржуулах, малчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэхэд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжтэй хамтран ажиллах; | Бат-Өлзий сумын бэлчээрийн даацыг Ус, цаг уур орчны шинжилгээний газраар тодорхойлуулсан. 1-р багийн бэлчээрийн нөөц хүрэлцээтэй, 2, 4 дүгээр багуудын бэлчээрийн даац 1-3 дахин хэтэрсэн, 3, 5 дугаар багуудын бэлчээрийн даац олон дахин хэтэрсэн зураглалтай гарсан тул малчдад энэ талаар мэдээлэл өгч, малчдын малыг чанаржуулах, малчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр бодлогын баримт бичгүүдэд шат дараатай ажлуудыг төлөвлөж, нэн тэргүүнд малчин өрх бүр малын тэжээл тарих уриалгад нэгдэж, 2023 оны 5, 6-р сард 50 гаруй малчин ногоон тэжээл тарьж, арвин ургац хураан авсан. 2023 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Бат-Өлзий суманд “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, зөвлөгөөнд 6 багийн 87 малчин хамрагдсан. Зөвлөгөөнд оролцсон малчдад бэлчээрийн даацад тохирсон малын тоо толгойн зохистой харьцааг бий болгох, малын эрүүл мэндийг хамгаалах, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг чанаржуулахад малчид өөрсдөө анхаарч ажиллах чиглэлийг өгсөн. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 25. | 4. б/мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээлийг хөгжүүлж, | 2023 оны 6-р сард 2-р багийн Засаг дарга Д.Бямбасүрэн нь “Share Mongolia” ХХК-тай хамтран багийнхаа 25 иргэнд | Бүрэн хэрэгжсэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | бэлтгэн нийлүүлэлт, анхан шатны боловсруулалт, борлуулалтын оновчтой сүлжээг бий болгох, загвар хоршоог байгуулах, шинэчлэх, хоршоолох хөдөлгөөнийг бүх талаар дэмжих; | цахилгаан багажаар хонь хяргах 5 хоногийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар 2350 толгой хонийг хярган өнгөөр, үргэлж хэвийн, бутархай 2,6 тн ноосыг ангилж сумын Дэлгэр баян ундрах хоршоонд тушаасан.<br>Малчдын хамтын хүч хоршоо 2.5 сая төгрөгөөр сарлагын хөөвөр самнах хашаа хийж 5 өрхийн 78 сарлагийг самнаж туршсан. Тус хоршоо 41 малчнаас 700 кг сарлагийн хөөврийг 20,0 төгрөгөөр, 167 малчнаас 3,8 тн ноолуурыг авч Үлэмж кашмер ХХК нийлүүлсэн. Борлуулалтын ашгийн зөрүүнээс 1 кг ноолуурт 1000-1500 төгрөгийн урамшуулал малчдад олгосон.<br>Тус хоршоо 2022 онд нэхий элдэх иж бүрэн төхөөрөмж худалдан авч суурилуулан 4-р багийн иргэн нДэлгэржаргалыг Улаанбаатар хотод 14 хоногийн сургалтанд хамруулсан. ХААБ-ээс түүхий эдийн агуулахын итгэмжлэлийн гэрээ байгуулсан.<br>Тус хоршооны дарга БНХАУ-ын Хөх хот руу мал нядалгаа цэг, эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 7 хоногийн туршлага судлах сургалтанд 2023 оны 6-р сард хамрагдсан. 2023 онд 1 хоршоо шинээр байгуулагдсан. | 100% | |
| | 26. | 5. в/цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, дотуур байрны суралцагчийн хоолны зардлыг шим тэжээл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагчийн хяналт, оролцоог хангах; | 1, 2 дугаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын баг 7 хоног бүр хүүхдийн хоолны норм, орчны эрүүл ахуй, хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын байдал, ажиллагсад болон бүтээгдэхүүний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэсэн эсэхэд байнгын хяналт тавьж хэвшсэн.<br>ЕБС-ийн захирлын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын зөвлөл байгуулагдан хяналт тавин ажиллаж байна. Эцэг, эх болон багш ажилчдаас санал авах хайрцаг ажиллуулдаг. Үдийн хоолыг 2023 оны 4-р сарын 17-ноос сургууль хариуцан нэг хүүхдийн 1500 төгрөгийн хоолыг чанаржуулан өгөхөд анхаарч ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгүүд өдөр бүрийн хоолыг ESIS програмд оруулан хүүхдийн хоолны шим тэжээлийг гаргахаас гадна эмч нар хоолны шим тэжээлийг давхар гараар тооцдог. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ЕБСургууль 2023 оны 5-р сарын 04-нд эцэг, эхийн хишиг өдрөөр 1-12-р бүлгийн давхардсан тоогоор 886 эцэг, эх, асран хамгаалагч нарт сургуулийн хамтын ажиллагаа, сургалт арга зүйн, дотуур байр, үдийн хоолны орц, амт чанарыг амтлуулж үйл ажиллагаагаа сурталчилсан.<br>1-р цэцэрлэг 2023 оны 2-р улиралд 10 бүлгийн 70 эцэг, эхчүүдэд хүүхдүүдэд өдөрт өгч байгаа хоолны орц, амт, чанар, шим тэжээлийн талаар хоолны амталгаат өдөрлөг зохион байгуулж, эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэн ажилласан. Тус үйл ажиллагаагаар 32 төрлийн хоол, жүүс бэлтгэн хоолны амт болон сэтгэл ханамжийн талаар судалгаа авч дүгнэхэд маш өндөр үнэлгээтэй гарсан байна. | | |
| | 27. | 5. к/хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах. | Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн нээлтийн арга хэмжээ, 6 багийн иргэдийн нийтийн хурлаар сумын Эрүүл мэндийн төвөөс иргэдэд хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх гарын авлага, сургалт, мэдээллийг өгсөн. Мэдээлэлд нийт 806 иргэн, ЕБС-ийн 8-12-р ангийн хүүхдүүд хамрагдаж, 428 гарын авлага тараасан. Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилтот жилийн нээлтийн үеэр сургууль, эрүүл мэндийн төв, цэцэрлэгийн гал тогоо, цайны газрууд, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, нэрийн хоол, амталгаат үзэсгэлэн зохион байгуулсан.<br>ЭМТөвөөс сургууль, 2 цэцэрлэг, 3 цайны газрын тогооч нарт давсны хэрэглээг бууруулах талаар ажлын байранд нь мэдээлэл зөвлөгөө өгсөн. Мөн ЕБС-ийн эцэг, эхчүүдэд хүүхдийн өглөөний уултын ач холбогдол сэдвээр сургалт хийсэн. Нийт 88 эцэг, эх хамрагдсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 11. | 28. | **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай. 2013.02.07 дугаар 20**<br>6/аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны ажилтны тоог тухайн аж ахуйн нэгж, | Жил бүрийн 4 дүгээр сарыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сар болгон зарлаж, ХАБЭА-н урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг. Энэ жил үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулах, ажилтны ажлын байран дахь осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл болон бусад эрсдэлт хүчин зүйлсийн | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагын ажилтны тоо, ажлын байран дахь эрсдэлийн түвшнээс хамааруулан тогтоох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл болон мэргэжлийн холбоотой хамтран ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах; | нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлын байрны соёлыг төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан олролцуулах тэдний сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг "Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эх" уриан дор Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулсан. Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, 1, 2 дугаар цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв зэрэг байгууллагууд "Эрүүл аюулгүй ажил-Бидний суурь эх" уриатай Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй-2023 сарын аянд нэгдсэнээр багш, ажилчид, суралцагсдад эрүүл аюулгүй байдал, ХАБЭА-н тухай хууль болон бусад хууль тогтоомжийн талаар мэдлэг мэдээлэлтэй болсон | | |
| Хэсгийн дундаж: 91,4 хувь | | | | | |
| **Гурав. Монгол Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол** | | | | | |
| 12. | 29. | "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ<br>3.8. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах. | Гэр бүлийн хүчирхийллийн шалтгаан нөхцөл нь 90 хувь нь архинаас үүдэлтэй. Сумын хэмжээнд архинд донтох өвчинтэй иргэдийн судалгаа, гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэх магадлалтай иргэдийн судалгааг гаргаж, нөлөөллийн олон талт ажлуудыг хамтран зохион байгуулж байна. Хамтарсан багийн гишүүд хамтарсан багийг чадавхжуулах танхимын болон цахимаар 3 удаагийн сургалтад хамрагдаж, гэр бүл, хүүхэдтэй ажиллах ур чадварт суралцсан.<br>Хүүхдийн бэлгийн хүчирхийллийн эсрэг "Үжин" төвийн тэргүүн Ундраа 2023 оны 04 дүгээр сарын 20-ний өдөр суманд ирж хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн сургалтыг зохион байгуулж 168 эцэг, эх, иргэн хамрагдсан. Гэр бүлийн хүчирхийллийн хор уршиг, гэр бүлийн харилцаа, эрүүл зөв амьдралын дадалд суралцах, хүүхэд хүмүүжүүлэх эрэг аргын талаар иргэд мэдээлэлтэй болсон. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Төвхөнбаярыг урин авчирч гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн харилцаа, тогтвортой гэр бүл, хүүхэд хүмүүжүүлэх | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | эерэг арга, угийн бичиг бичихийн ач тус сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 96 иргэн хамрагдсан. | | |
| 13. | 30. | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай<br>2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ<br>2.1/. Хүн амын дунд БЗДХ-т өвчин нэмэгдэж байгаатай холбогдуулан аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигтээ ХДХВ ын халдвар, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгаж, хэрэгжилтийг хангах; | Сумын Эрүүл мэндийн төвд 2023 оны эхний 6 сарын байдлаар нийт 134 хүнд ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн тестээр шинжилгээ хийхэд ДОХ \-\, трихомонайзын халдвар 4 илэрснийг хавьтагчийн хамт эмчилсэн. ЭМТөвийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтан Г.Ганчимэд ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчдад бэлгийн ариун цэвэр, хүсээгүй жирэмслэлт, ХДХВ\ДОХ-ын талаар сургалт хийж, хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, ДОХ болон БЗДХ-аас урьдчилан сэргийлэх мэдээллийг тогтмол өгч ажиллагдаг. Сургалт, сурталчилгаанд давхардсан тоогоор 600 гаруй сурагч хамрагдсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| Хэсгийн дундаж: 100 хувь | | | | | |
| **Дөрөв. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 14. | 31. | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2021.10.04 дугаар58<br>1.6.Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Сумын цэцэрлэгт хүрээлэнгээс гадна 2023 онд “Их сумт хайрхан” ХХК нь 0,5 га газарт өөрийн хөрөнгө оруулалтаар бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулан, 1000 гаруй мод бут тарьж, нийгмийн хариуцлагаа ухамсарлан эх байгаль дэлхийдээ бодит хувь нэмэр оруулла. Мөн айл бүр хашаандаа 5-аас доошгүй мод тарьж ургуулах уриалгыг иргэдэд сурталчлан ажилласан. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 1200 иргэнд тарааж, цахимаар сурталчилсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 32. | 1.8.Байгалийн бүс, бүслүүрийн хөрс, цаг агаарын онцлогт тохируулан мод тарьж ургуулах арга, орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, нэгдсэн зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх, хот, суурин газрын ногоон байгууламжийг хот байгуулалтын нэгдсэн төлөвлөлттэй уялдуулан бие даасан салбар | Хангайн бүсийн онцлогт тохируулан мод, бут тарьж ургуулах арга техникийг сурталчилсан шторкийг албан байгууллага, аж ахуйн нэгж, сумын нийт иргэдэд сурталчлан таниулж, багийн иргэдийн нийтийн хурлуудаар 800 гаруй иргэнд гарын авлага материал тараасан. Сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу мод үржүүлгийн зориулалтаар | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | болгон хөгжүүлэх | Их сумт хайрхан ХХКомпанид 3 га газар олгож, газрын асуудлыг шийдвэрлэж өгсөн. | | |
| 15. | 33. | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>2021-08-27 Дугаар 2021_23<br>1.1.Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх. | Энэ жил Бат-Өлзий сумаас элсэлтийн ерөнхий шалгалтыг 70 хүүхэд өгөхөөс 70 хүүхэд шалгалт өгсөн. Сумын дундаж оноо 530. 2023 оны ЭЕШалгалтын тэтгэлэгт хөтөлбөрт 1 хүүхэд хамрагдсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 16. | 34. | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай<br>2018-05-23 Дугаар 2018_46<br>3.Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, ЕБС, Цэцэрлэгүүд, Соёлын төв, Эрүүл мэндийн төв гадна болон өрөө тасалгааны хаягаа монгол бичгээр бичиж үйлдсэн.<br>Үндэсний бичгийн баярын өдрийг тохиолдуулан Соёлын төвөөс “Үсэг бичиг- үндэсний бахарал” сэдэвт уран бичлэгийн уралдаан зохион байгуулсан. Үндэсний их өв соёл босоо бичгээ хичээнгүйлэн сурч энэ төрлөөр зохион байгуулагдаж буй цахим уралдаан зохион байгуулж дүгнэсэн. Засаг даргын Тамгын газрын Насан туршийн боловсролын нэгжид Соёлын төв, ХААН банкны албан хаагчид болон иргэд нийт 20 хүн Үндэсний бичгийн сургалтад хамрагдсан. ЕБС-ийн дунд болон ахлах ангийн 35 сурагч үндэсний бичиг, бийрэн бичгийн сургалтад хамрагдсан. Сургалтыг иргэн Ц.Баасанжав зохион байгуулж, сумын ЗДТГ-аас өрөө байрыг шийдвэрлэж өгсөн. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 35. | 4.Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус | ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын багш нараас Төрийн албан хаагчид болон иргэдэд зориулан “Үндэсний бичгээ бие даан суръя” гарын авлагыг бэлтгэн тараасан. Багийн иргэдийн нийтийн хурлаар иргэдэд мэдээлэл өгч, гарын авлага тарааж ажилласан. Төрийн албан хаагчид үндэсний бичгээ цахимаар бие даан судалж байна. | Хэрэгжих шатанд 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгууллагуудад уриалсугай. | | | |
| 17. | 36. | **Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай**<br>**2017.07.10 дугаар 186**<br>1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.<br>2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж заншиx, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай. | Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, таниулах зорилгоор бүх байгууллагуудад албан бичиг хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж заншиx, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг албан байгууллагууд болон аж ахуйн нэгж, иргэдэд уриалж, цахим хуудсаар сурталчилсан.<br>Дижитал мэппинг ХХК нь 2022 оны 12 дугаар сарын 06-нд 745 ширхэг газар зүйн нэрийн 4 хавтас хувийн хэрэг, УИХ-аар батлуулах газар зүйн нэрийн жагсаалт, газар зүйн нэрийн зураг, ажлын тайланг хүлээн авсан. 2023 онд Газар зүйн нэрийн тоон мэдээлэл (shp)-ийг Өвөрхангай аймгийн ГХБХБ-ын газарт хүлээлгэн өгч улсын хаягийн мэдээллийн санд бүртгэн оруулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 18. | 37. | **Мод тарих үндэсний өдөр зарлах тухай**<br>**2010.04.14 дугаар 63**<br>1. жил бүрийн 5,10 дугаар сарын хоёр дахь долоо хоногийн “Бямба” гарагийг бүх нийтээр мод тарих үндэсний өдөр болгон зарласугай.<br>2. Мод тарих үндэсний өдөр бүх нийтээр мод, бут, сөөг, цэцэг тарих, цаашид арчлан хамгаалах, түүнийгээ амьдралын хэв маяг болгон хэвшүүлэн сурталчилж ажиллахыг Монгол Улсын нийт ард иргэд, айл өрх, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хандивлагч нарт уриалсугай. | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 1200 иргэнд тарааж, цахимаар сурталчилсан. 2023 онд мод тарих арга хэмжээнд нийт 8 аж ауйн нэгж, 15 нөхөрлөлийн 222 иргэн оролцож 12 төрлийн 6457 ширхэг мод, бут сөөг тарьж, төлөвлөгөө давуулан биелүүлж, ургалт 85 хувьтай. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| Хэсгийн дундаж: 91,4 хувь | | | | | |
| **Тав. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж** | | | | | |
| 19. | 38. | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион | Иргэдэд экологийн боловсрол олгох, иргэдийг соён | Бүрэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021.09.30 Дугаар 03<br>3.5.Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | гэгээрүүлэх чиглэлээр 2 удаагийн сургалт, багийн иргэдийн нийтийн хурлуудаар мэдээлэл хийж, мод тарих аргачлал, хууль бус мод бэлтгэл, хууль эрх зүйтэй холбоотой 1200 гаруй ширхэг гарын авлага хийж тараасан. Сургалт, сурталчилгаанд нийт 802 иргэн хамрагдсан.<br>Хүрээлэн буй орчны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сурталчилсан сурталчилгааны стэнд хийж, иргэдэд харагдахаар ил байршуулсан. | хэрэгжсэн 100% | |
| 20. | 39. | Усны нөөцийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, усны чанар, аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай<br>2019-12-31 Дугаар 60/40<br>2.2.Хүн амын ундны ус хангамжийн баталгаат байдлыг хангах үүднээс хот, суурин газрын ус хангамжийн эрүүл бүсийг тогтоон, хамгаалалтад авч газар олголт хийхгүй байх, газар чөлөөлөх ажлыг орон нутгийн удирдлагууд шуурхай зохион байгуулах. | Сумын төвийн иргэдийн ундны усыг хангаж буй 9 худаг ажилладаг. Жил бүр ундны уснаас дээж авч шинжилгээнд хамруулж, ундны усны худгуудын орчны эрүүл ахуй, хамгаалалтад Байгаль орчны хяналтын улсын байцаагч хяналт тавьж, худаг ус хариуцсан эздэд үүрэг чиглэл өгч, хамгаалалтын бүсэд газар олголт хийгээгүй. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 40. | 2.11.Хот, суурин газрын үерийн хамгаалалтын далан, ус зайлуулах системийн найдвартай ажиллагааг хангах | Бат-Өлзий сумын төвд өнгөрсөн жил олон өдрийн усархаг, аадар бороо орсны улмаас үер бууж олон айл өрх үерт автаж эд хөрөнгөөрөө хохирсон. Наймаа булан, Өвт, Бэл хорооллын үерийн далан барих ажлын зураг төсвийг 20,0 сая төгрөгөөр хийлгүүлж, Үерийн далан барих ажлыг ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийхээр 2023 оны төсөвт 162,2 сая төгрөг батлуулсан. Тус ажлын тендерийг 2 удаа зарлаж “Тулгат зам” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж байна. | Хэрэгжих шатанд 70% | |
| Хэсгийн дундаж: 90 хувь | | | | | |
| **Зургаа. Монгол Улсын Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 21. | 41. | **Ерөнхий төлөвлөгөө батлах тухай /хүний эрх/**<br>**2023.09.23 дугаар 357**<br>4. ерөнхий төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг харьяа нутаг | Хүний эрхэд суурилсан жендерийн мэдрэмжтэй ажиллах талаар төрийн байгууллагууд бодлого, төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна. 2023 онд иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн ажлын чиглэлээр иргэдийн дунд бие бялдарын түвшин тогтоох сорилд 242 иргэдийг хамруулж | Хэрэгжих | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дэвсгэртээ зохион байгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн засаг дарга нар, уг үйл ажиллагаанд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг гадаад харилцааны сайд б.батцэцэгт тус тус үүрэг болгосугай. | эрэгтэй 122 иргэн, эмэгтэй 120 иргэн хамрагдсан байна. Илүүдэл жингийн хор уршгийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Сумын ЭМТ-тэй хамтран 18-35 насны 20 залуучуудад нөхөн үржин эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт чиглэлээр мэдээ мэдээллийг хүргэж ажилласан байна. | шатанд 70% | |
| 22. | 42. | **Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаарыг тогтоох тухай**<br>**2023.08.23 дугаар 304**<br>1."2024 онд цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн тооны дээд хязгаар"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>2.Цэргийн дүйцүүлэх алба хаах арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2023 онд дүйцүүлэх албанд 6 цэрэг алба хааж байгаа ба дүйцүүлэх албаны цэргүүд тэр бум мод хөдөлгөөний хүрээнд мод тарих, газар тариалан, өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлууд болон сум, аймгийн бүтээн байгуулалтын ажлуудад ажиллуулж журмын дагуу дүйцүүлэх албыг хаалгаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 23. | 43. | **Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай**<br>**2023.07.19 дугаар 279**<br>2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 03 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны А/499 дугаар захирамжийн дагуу бэлтгэл ажил хангах, батлагдсан төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын 2023 оны А/172 дугаар захирамж гарган өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хэсэг, хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилласан. Үүнд төлөвлөгөөний дагуу сумын нөөцөд 50 тн тэжээл, 40 тн багсармал хүчил тэжээл, малчдын түвшинд 2420 тн өвс, 807 тн гар тэжээл, 1615 тн хужир шүү тус тус бэлтгэж, зах зээлд борлуулсан малын хувьд адуу 285 тоо толгой, үхэр 428 тоо толгой, хонь 225 тоо толгой, ямаа 262 тоо толгой буюу нийт 1200 тоо толгой мал амьдаар зах зээлийн эргэлтэд оруулсан. Өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажил хангах төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн тайланг ХХААГ-т хүргүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 24. | 44. | **Ерөнхий боловсролын сургуулийн ачааллыг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай**<br>**2023.06.21 дугаар 234**<br>1.1.улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө | 2023 онд Улсын төсвийн 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 440 хүүхдийн сургууль шинээр барьж, улсын комисс хүлээн авсан. Шинэ сургууль хичээлийн жилийн 3 дугаар улирлаас ашиглалтад орно. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | оруулалтаар баригдаж байгаа 2023-2024 оны хичээлийн жилд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөн ерөнхий боловсролын сургуулийн зориулалттай барилга байгууламжийн барилгын ажлыг эрчимжүүлж, бүрэн ашиглалтад оруулах арга хэмжээ авах, нэмэлт санхүүжилт шаардагдах тохиолдолд эх үүсвэрийг 2024 оны улсын болон орон нутгийн төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | | | |
| 25. | 45. | Хяналт шалгалт хийх нийтлэг журам батлах тухай<br>2022.12.28 дугаар 479<br>2.Эрхэлсэн салбарын онцлогийг харгалзан салбарынхаа хэмжээнд мөрдөгдөх хяналт шалгалт явуулахтай холбогдсон журам, заавар, маягт, аргачлал, хяналтын хуудсыг хууль тогтоомж, энэ тогтоолын 1-д заасан нийтлэг журам, загварт нийцүүлэн баталж, мөрдүүлэхийг эрх бүхий төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагын удирдлагад тус тус даалгасугай. | Улсын ерөнхий прокурорын баталсан шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загварын дагуу зөрчилд дугаар авах, хялбаршуулан шийдвэрлэх журмаар зөрчлийн хэрэг бүртгэлийг цаг хугацаанд нь зохион байгуулж, 2023 онд Байгаль орчны хяналтын улсын байцаагч нийт байгаль орчны чиглэлээр гомдол мэдээллийн 15 дугаар, зөрчлийн 9 дугаар авч бүртгэлд оруулан 100 хувь шийдвэрлэсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 26. | 46. | Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай<br>2023.04.05 дугаар 119<br>2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хэлбэрээр хаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | 2023 оны ээлжит цэрэг татлагаар 1996 оны 36 иргэн, 1997 оны 47 иргэний мөнгөн төлбөрийн тооцоог бүрэн хийж дууссан. Мөнгөн төлбөрийн тооцоотой иргэн байхгүй. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 27. | 47. | 2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай<br>2023.02.08 дугаар 49<br>1.Монгол Улсын хөгжлийг боомилон сааруулагч | Төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | гол хүчин зүйлс болох авлига, албан тушаалын гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах нийгэм, эдийн засаг, эрх зүй, зохион байгуулалтын олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлж, авлига, хууль бус үйлдэлтэй үл эвлэрэх, үл тэвчих хандлагыг олон нийтийн дэмжлэг, оролцоотойгоор төлөвшүүлэн бүх шатанд авлигыг таслан зогсоосны үндсэн дээр хүний эрхийг ханган нийтийн эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийг дэмжин хөгжүүлж эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2023-2024 оныг "Авлигатай тэмцэх жил" болгон зарласугай.<br>3.Авлигатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.<br>4.Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлэх авлигатай тэмцэх ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллахыг иргэд, олон нийтэд уриалсугай. | зорилгоор Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуульд заасан шаардлагуудын дагуу төрийн байгууллагуудад чиглэл хүргүүлсэн.<br>Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг цахимаар сурталчилсан. Авлигын эсрэг чиглэлээр бэлдсэн видео болон радио контент, зурагт хуудас, нугалбар, подкаст, үзүүлэн таниулах хуудас, мэдээллийн самбар, видео болон цахим хичээл зэргийг сумын цахим хуудас, олон нийтийн сүлжээ Facebook, нийтийн тээвэр, сурталчилгаа, гудамжны самбар болон дэлгэц, хэд хэдэн төрөл хэлбэрээр түгээсэн.<br>Засгийн газраас 5ш ажиллагааны хүрээнд авч байгаа судалгааг гарган хугацаанд холбогдох байгууллагад хүргүүлсэн. Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газар “Авлигын эсрэг хамтдаа” 110 самбарыг хийж байршуулсан. Самбарт гомдол мэдээлэл хүлээн авах утас, Авлига, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, холбогдох хууль тогтоомжийн талаарх мэдээллийг шинэчлэн хийж байна.<br>2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр Сумын ГХУСАЗСЗөвлөлөөс төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор СӨББ-1, СӨББ-2-ын албан хаагчдад Авлигын тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад 2 байгууллагын 48 албан хаагч хамрагдсан. | | |
| 28. | 48. | Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр дугаар 448<br>1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төрийн албан хаагчийн ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангаж хэт | 1.12. сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоол, мөн “Сумын 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2023 оны 07 дугаар сарын 19-ны 15/01 дүгээр тогтоолоор төрийн захиргааны албан хаагчдад олгох орон нутгийн нэмэгдлийг 70 хувиар тогтоон олгож байна.<br>1.13. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24 ны өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төвлөрлийг бууруулах, батлагдсан төсвийг үр дүнтэй, үр ашигтай зарцуулах зорилгоор дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай:<br>1.12.гүйцэтгэсэн ажлын бүтээмжийг нь харгалзан аймаг, сумын засаг захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдын үндсэн цалинг хоёр дахин хүртэл нэмэгдүүлсэн хэмжээгээр тооцож, орон нутгийн нэмэгдлийг батлагдсан төсөвтөө багтаан олгох арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>1.13.орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын арга хэмжээг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавихад холбогдох хууль тогтоомжийг баримталж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>1.14.ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний хүрээнд нутгийн захиргааны байгууллагад өгсөн хандив, тусламжийг аймаг болон сумын орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлж, орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрт хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>1.16.нийслэлээс орон нутагт үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид бизнесээ эрхлэхэд нь зориулж газар болон холбогдох тусгай зөвшөөрөл олгох арга хэмжээг хүнд сурталгүйгээр шуурхай шийдвэрлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;<br>2.Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг | хөгжлийн сангийн үйл ажиллагааны шинэчилсэн журам”-ыг мөрдөж, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцдог бүх шатны албан хаагчдад танилцуулан ажиллаж байна. Мөн ЗДТГ-ын Санхүүгийн албанаас Орон нутгийн хөгжлийн сан, “Худалдан авах ажиллагаа” чат групп нээж, үүнд шинэчилсэн дүрэм, журам, заавар, зөвлөгөөг тогтмол өгч хэрэгжүүлдэг.<br>2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс 847,0 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 178.0 сая төгрөг буюу нийт 1,025,0 сая төгрөгний 28 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулснаас 22 төрлийн 731.8 сая төгрөгний ажил хэрэгжиж байна. Үүнээс: Нээлттэй тендер 3 ажил буюу 364.2 сая төгрөг, ТШОЖ-Харьцуулалтын аргаар 3 ажил 188,6 сая төгрөг, шууд худалдан авалтын аргаар 15 буюу 127.8 сая төгрөгний хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүн, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан.<br>1.14. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ байхгүй.<br>1.16. 2023 онд нийслэлээс суманд үйл ажиллагаагаа шилжүүлсэн аж ахуйн нэгжид байхгүй.<br><br><br>2.1 2023 оны төсөвт шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсөвтэй 30 төсөл, арга хэмжээг баталж боловсруулсан. Зураг төсвийн зардал гараагүй хэмнэсэн.<br>2.2. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон төсвийн хэмнэлтийг зарцуулаагүй хэмнэсэн.<br>2.3. Орон нутгийн хөжглийн сангийн хөрөнгө оруулалтаар буюу төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ХАА-г тухайн төсвийн жилийн 05 дугаар сарын 01 -ны өдрийн дотор | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:<br>2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;<br>2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;<br>2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах;<br>2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; | зохион байгуулсан. 22 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон.<br>2.4. 2 дугаар багийг өндөр хүчдэлд холбох, тог татах үлдэгдэл, Хөл бөмбөгийн талбайтай болох, Сумын төвийг танилцуулах, сурталчлах өндөрлөгтэй болох зэрэг ажлуудын батлагдсан төсөв барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдлээс шалтгаалж хэрэгжээгүй, үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хийж 2024 онд шилжих хөрөнгө оруулалтаар шаардлагатай төсвийг нэмж батлуулахаар өргөн барьсан. | | |
| 29. | 49. | Журам батлах тухай<br>2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр<br>Дугаар 201<br>1. "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон энэ журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төсөвт байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | Засаг даргын Тамгын газар “Нэг цонхны үйлчилгээний төв”-д төрийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд нэг цэгээс хүргэж байна. Байгууллагуудаас үзүүлж буй төрийн үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бичиг баримтыг ил тод байршуулж, гарын авлага бэлтгэн олшруулан иргэдэд тарааж, Цахимаар авах үйлчилгээний жагсаалтыг олон нийтийн сүлжээгээр иргэдэд сурталчлан таниулж, ЗДТГ-ын цахим хуудас, мэдээллийн самбар, Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар дамжуулан хүргэж байна.<br>http://bat-ulzii.ov.gov.mn/ цахим хуудсанд нээлттэй мэдээллүүдийг байршуулж, шинэчлэн, хяналт тавин ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 30. | 50. | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 204<br>1. Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.<br>2. Энэ тогтоолын 1-д заасны дагуу татан төвлөрүүлсэн төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашиныг "Засгийн газрын автобааз" УТҮГ-т, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тухайн аймаг, нийслэлийн харьяа автотээврийн байгууллагад шилжүүлж, төрийн болон орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.<br>9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн | Аймгийн Засаг даргын “Автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/415 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, шийдвэрийг төрийн байгууллагуудад хүргүүлж, хяналт тавин, байгууллагууд албаны автомашиныг журмын дагуу ашиглаж байна. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын автомашиныг Засаг даргын Тамгын газарт шилжүүлж, Засаг даргаас өөр албан тушаалтан албаны автомашин хэрэглээгүй. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого, нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | | | |
| 31. | 51. | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 203<br>1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай:<br>1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх; | Сумын 2024 оны төсвийн төслөө Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулийн хугацаанд өргөн барьсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 52. | 1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах; | Төрийн албан хаагчид 2023 онд цаг үеийн эрэлт шаардлага, мэргэжлийн сургалт, байгууллагын дотоод сурталтад давхардсан тоогоор 533 албан хаагч хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. Зохион байгуулагдаж буй сургалт, семинар, хурал, зөвлөгөөний дийлэнх нь цахимаар явагдсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 32. | 53. | Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай<br>2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Дугаар 180<br>3. Харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн | Бат-Өлзий сум 2018 онд Орон нутгийн хөгжлийн сангийн 20,0 сая төгрөгөөр сумын төвийн хаягжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 10 дугаар сарын 08 ны өдрийн 23 дугаар тогтоолоор гудамж, хороо, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулсан. | Бүрэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хаягийн мэдээллийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, хаягжуулах ажлыг шуурхай, үр дүнтэй зохион байгуулах, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, хаягжуулалтын үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай. | Тогтоолыг дагуу сумын хэмжээнд нийт 1447 нэгж талбар, 71 барилга, 112 гудамж шинэ хаягтай болсон. Нэгж талбарын хаягаа тогтмол хаягжуулалтын мэдээллийн санд бүртгэж, 2023 онд 95 нэгж талбарын гудамж талбайн нэр өөрчлөх, шинээр 47 нэгж талбарыг хаягжуулсан. | хэрэгжсэн 100% | |
| 33. | 54. | Хүнсний ногооны үйлдвэрлэлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2022-03-16 Дугаар 118<br>5.Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор иргэдийн төмс, хүнсний ногоо тариалах идэвх, санаачилгыг дэмжих, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх болон хүнсний ногооны тээвэрлэлт, хадгалалт, худалдааны сүлжээг хөгжүүлэх, хөдөөгийн хүн амын хүнсний ногооны хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх зорилгоор 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэдэд газар тариалангийн чиглэлээр 6,6 га газар эзэмшүүлэхээр тусгагдаж, хэрэгжилтийг зохион байгуулан 3,2 га газрыг эзэмшүүлсэн. 2023 онд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нийт 10 га-д төмс, 3 га-д хүнсний ногоо тарих төлөвлөгөөтэйгөөс Төмс 11 га-д төмс, Хүнсний ногоо 3 га-д тариалалт хийсэн. Тариалан эрхлэгчид тариалангийн газрыг зориулалтын дагуу үр шимийг алдагдуулахгүй ашиглаж байна. ОНХСангийн 82,0 сая төгрөгийн хөрөнгөөр газар тариалангийн зориулалттай 80 морины хүчин чадалтай тракторыг дагалдах эд ангийн хамт худалдан авч ашиглаж байна. Зорилт жилийн хүрээнд 9 нэр төрлийн хүнсний ногооны үр, төмсний үр 80 хувийн хөнгөлөлтэй үнээр ирснийг 46 өрхөд тарааж өгсөн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 34. | 55. | Журам батлах тухай<br>2022-03-02 дугаар 92<br>2.“Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>3.Удам зүйн үнэт чанарын хувьд өвөрмөц, хязгаарлагдмал нөөц, тархалт бүхий мал, амьтныг хамгаалах, зохистой үржүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | Бат-Өлзий суманд Эрчмийн хар омгийн ямаагаар 2 өрх, Баянгол үүлдрийн хуцаар 5 өрх, араб адуугаар 2 өрх тус тус мал сүргээ сайжруулан, малчид малаа зохистой үржүүлэхэд нутгийн онцлогт тохирсон хээлтүүлэгч буюу монгол, завханы буурал, эрчмийн хар, баяндэлгэрийн улаан гэсэн үүлдэр омгийн ухнаар, монгол, баяд, тамир, хотонт, баянгол үүлдэр омгийн хуцаар хээлтүүлэгч тавихад тохиромжтой талаар Хөдөө аж ахуйн тасгаас малчдад мэдээлэл өгсөн. | Хэрэгжих шатанд 70% | |
| 35. | 56. | Хоршооны хөгжлийг дэмжих талаар авах зарим арга хэмжээний тухай | Хоршооны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор хоршоодыг шинэчилсэн бүртгэлд | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2022.02.23 Дугаар 81<br>3.“Хоршооны хөгжлийг дэмжих жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Жижиг, дунд үйлдвэрийн газар (Я.Эрдэнэсайхан)-т тус тус үүрэг болгосугай | хамруулах ажлыг орон нутгийн хүрээнд зохион байгуулсан. Нийт 14 хоршоо бүртгэлтэй.<br>2023 онд Цэлгэрийн шоргоолж хоршоонд газар тариалан эрхлэх зориулалтаар хоршоо хөгжүүлэх сангаас 20,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл, Урд агуйт хайрхан хоршоонд ЗДТГ-ын өмчийн газар тариалангийн зориулалттай тракторыг гэрээгээр эзэмшүүлсэн. Малчдын хамтын хүч хоршооны дарга БНХАУ-ын Хөх хот руу мал нядалгааны цэг, эрчимжсэн аж ахуйн чиглэлээр 7 хоногийн туршлага судлах сургалтад хамрагдсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 36. | 57. | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-01-05 Дугаар 7<br>5.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай:<br>5.2. Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;<br>5.3. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх | -Төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг эзэмшүүлэх, дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна. Ерөнхий боловсролын сургуулийн монгол хэл, уран зохиолын 8 багш 5 байгууллагын 150 албан хаагчид үндэсний бичгийн хичээл зааж анхан шатны мэдлэгийг эзэмшүүлсэн.<br>-Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, ЕБС, Цэцэрлэгүүд, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нь гадна болон өрөө тасалгааны хаягаа монгол бичгээр үйлдсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 37. | 58. | Журам шинэчлэн батлах тухай<br>2022-01-05 дугаар 02<br>1.”Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.<br>2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилтийг хангуулан ажиллаж төсөв хуваарилалтыг 2023.03.15-нд байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллийн сайтад оруулсан. Сангаас 393,0 сая төгрөгийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 7 арга хэмжээ 100 хув хийгдэж, 2 арга хэмжээ 2024 онд хийгдэхээр хойшилсон. 2024 оны төлөвлөлт болон давсан орлогыг хугацаанд нь БОАЖЯамны Байгаль орчныг хамгаалах, | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | нөхөн сэргээх зардлын мэдээллийн санд 2а, 2б маягтын дагуу хугацаанд шивж оруулсан. | | |
| 38. | 59. | **Босго үнэ шинэчлэн батлах тухай**<br>**2021.05.05 дугаар 124**<br>2. Энэ тогтоолоор баталсан босго үнийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллахыг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд даалгасугай. | Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг энэ тогтоол гарснаас хойшхи бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 39. | 60. | Журам шинэчлэн батлах тухай<br>2021.01.06 дугаар 05<br>3. Малын тоог бэлчээрийн даацад тохируулан бэлчээрийг зохистой ашигласан, малын чанарыг сайжруулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэн, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд малаа бүрэн хамруулсан, эрүүл чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, тэдний нийгэмд оруулж байгаа хувь нэмэр зэрэг шалгуур үзүүлэлтээр орон нутагтаа тэргүүлсэн малчин өрх, саальчин, фермерийг шалгаруулан шагнан урамшуулж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | 2023 онд журамд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж аймгийн аварга малчин өрх 4, аймгийн аварга саальчин 1, аймгийн аварга тариаланч 1, Сумын аварга малчин өрх 12, сумын аварга фермерч 1 тус тус шалгаруулж, шагналыг гардуулан өгсөн. Аймаг, сумын аварга малчдад хүндэтгэл үзүүлэх зардалд сумын Засаг даргын нөөц сангаас 4,0 сая төгрөг зарцуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 40. | 61. | Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2020.12.23 Дугаар 235<br>4. Бүх шатны сургалтын байгууллагын барилга байгууламж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх зайлшгүй шаардлагатай тохирох | Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах нийгмийн ажилтнаар ахлуулсан “Дэмжлэг баг” байгуулан ажиллаж байна. 1-5 дугаар ангийн 5 сурагчийг багш тус бүр нь ганцаарчилсан хөтөлбөрөөр сургаж байгаа. Ганцаарчилсан хөтөлбөрөөр сургаж байгаа багш нарт урамшуулал олгуулах санхүүжилтыг төсөвт тусган нэмэгдлийг олгож байна. Мөн унших бэрхшээлтэй сурагчдад уншуулах зорилгоор Сурагчдын зохиосон “Банхарын адал явдал” 15 цуврал 3D болон сонсдог ном хийсэн. Цаашид “Зохиолч” клубийг чиглүүлэн ажиллаж, судалгаагаа үргэлжлүүлж байна.<br>Хичээлийн 2 дугаар байрны гадна хөгжлийн бэрхшээлтэй | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэглэгдэхүүний зардлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан шийдвэрлэж байхыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.<br>6. Бүх шатны сургалтын байгууллагын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан зохих стандартад нийцүүлсэн зам, талбайтай болгох арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай. | суралцагчид зориулсан налуу стандартын орж, гарах шаттай.<br>Өвөрхангай аймгийн Насан туршийн боловсролын төв, сумын ЗДТГазар хамтран ЯХИСангийн хөрөнгө оруулалттай “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй малчин эцэг, эхийн бичиг үсгийн боловсролыг сайжруулах замаар амьдралын чанарыг дээшлүүлэх нь” төслийг сумандаа хэрэгжүүлж 18 эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй 11 хүүхэд уг төсөлд хамрагдаж, бичиг үсгийн боловсролыг сайжруулж, амьдрах ухааны сургалтуудыг маш үр дүнтэй зохион байгуулж дууссан. Сумын НТБоловсролын нэгжид хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхдэд гарцаарчилсан төлөвлөгөө боловсруулан хичээл заасан. | | |
| 41. | 62. | Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай<br>**2020.11.18 дугаар 184**<br>1. Ойгоос бэлтгэж ашиглах 1 шоо-метр хэрэглээний мод, түлээнд ногдуулах төлбөрийн хэмжээг 1 дүгээр хавсралт, ойд арчилгааны огтлолт хийх болон ойн цэвэрлэгээний аргаар хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөрийг хөнгөлөх хувь, хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тогтоосугай.<br>2. Тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай. | 2023 онд ойгоос “Бэлтгэх модны тоо хэмжээ тогтоох тухай” Өвөрхангай аймгийн ИТХурлын 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 14/07 дугаар тогтоол, Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчидийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 29 өдрийн 10/02 дугаар тогтоолоор хэрэглээний 6200$м^3$, түлээний 15300$м^3$ нийт 21500$м^3$ бэлтгэх модны хуваарь гарч, 2023 онд сумын хэмжээнд 8 ойн мэргэжлийн байгууллага, 8 ойн нөхөрлөлтэй гэрээ байгуулж, 128 га талбай тусгаарлалт хийж, цэвэрлэгээний огтлолт 34 га-д, хэрэглээний 1456 м3, түлшний мод 9180 м3, Өрхийн түлээнд 837 өрхөд 5534 $м^3$, байр саравчны зориулалтаар 4 өрхөд 32$м^3$ нийт хэрэглээний 1488$м^3$, түлшний 1180$м^3$, нийт 10668$м^3$ мод бэлтгэн орон нутгийн төсөвт 55.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн. 2023 онд иргэдэд 1878 ширхэг эрхийн бичиг, гадагш тээвэрлэлтэд 931 ш гарал үүслийн бичиг олгож, хяналт тавин ажилласан байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 42. | 63. | Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай<br>2020-05-06 Дугаар 163<br>3.Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, | Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн нэгдсэн системийн шинэчлэгдсэн программд төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээлэл болон алдаатай мэдээллийг тухай бүр засаж шинэчилдэг. Үүнд: ИТХурлын 4, ЗДТГазрын 23, ЭМТөвийн 35, ЕБСургуулийн | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай. | 135, 1 дүгээр цэцэрлэгийн 34, 2 дугаар цэцэрлэгийн 18, Соёлын төвийн 6, нийт 255 албан хаагчийн мэдээлэлд хяналт тавин ажиллаж байна. Байгууллагуудын хүний нөөцийн систем хариуцан гаргадаг албан хаагчдаас нууцын баталгаа гаргуулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан. | | |
| 43. | 64. | Журам батлах тухай<br>2020.03.25 Дугаар 113<br>1. “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2020 оны 49, 251 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон)<br>2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Энэ жил аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлттэй зээл олгоход иргэдээс төсөл хүлээн авах хугацааг товлон төсөл хүлээн авах мэдээллийг ирүүлсний дагуу төсөл хүлээн авах зар мэдээг сумын зарын групп, олон нийтийн сүлжээгээр түгээж, иргэдээс аймаг руу төсөл явуулж Бат-Өлзий сумын Их сумт хайрхан ХХК мод үржүүлгийн чиглэлээр 279.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч үйл ажиллагаа явуулж байна. | Хэрэгжих шатанд 70% | |
| 44. | 65. | Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай 2019-12-25 Дугаар 474<br>5.Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан хот, суурин газарт ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж болон цэвэрлэх байгууламж, төвлөрсөн дулаан хангамжийн систем, нийтийн халуун усны төв бий болгоход шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжид нэн тэргүүнд хамруулах замаар санхүүжүүлж ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Бат-Өлзий суманд “Шинэ сум” төсөл хэрэгжиж, төслийн хүрээнд ус хангамж, ариутгах татуурга, ариун цэврийн байгууламж болон цэвэрлэх байгууламж, төвлөрсөн дулаан хангамжийн системд холбогдохоор улсын төсвийн 6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар томоохон бүтээн байгуулалтын ажлыг “Дуутын нуруу” ХХК, “Юу зэт эрдэнэ” ХХК гүйцэтгэж байна. Гүйцэтгэл 80 хувьтай. | Хэрэгжих шатанд 70% | |
| 45. | 66. | Бэлчээр хамгааллын ажлыг эрчимжүүлэх тухай 2019.05.01 дугаар 185 | “Бэлчээр хамгаалах өдөр”-ийг цахимаар иргэдэд сурталчилсан. Бэлчээрийг зүй зохисой ашиглах, | Бүрэн хэрэгжсэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 4. 2019 оны бэлчээр хамгааллын арга хэмжээг нийтийг хамарсан ажил болгон зохион байгуулах, цаашид жил бүрийн 5 дугаар сарын эхний долоо хоног болон 10 дугаар сарын сүүлийн 7 хоногийн Баасан, Бямба, Ням гарагийг “Бэлчээр хамгаалах өдөр” болгон зарлаж, мэрэгч амьтан, шавжны хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах бүх нийтийн арга хэмжээг сум, багийн түвшинд зохион байгуулж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | хамгаалах чиглэлээр малчид иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч, жил бүр сумын Засаг даргын захирамжаар өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх, өнжөөх, сэлгээх шийдвэрийг гаргаж, багийн Засаг дарга нар, иргэд мөрдөж, хэрэгжүүлж ажилласан. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар 2023 оны бэлчээрийн менежментийг төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.<br>Орон нутгийн хөгжлийн сангийн малын хөлийн албан татварын орлогоос урт хугацааны бэлчээрийн менежментийн төлөвлөгөө хийлгэхээр төлөвлөж иргэдээс санал авч эрэмбэлэхэд санал дэмжигдэж 2024 оны төсөвт тусгуулсан. Манай суманд бэлчээрийн мэрэгч амьтан, шавж одоогоор илрээгүй. | 100% | |
| 46. | 67. | Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай<br>2019.04.17. дугаар 149<br>3. Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй. | Бат-Өлзий сумын ЗДТГазрын оператор хариуцсан мэргэжилтэн нь ХУР системээс 2023 онд нийт 1410 лавлагаа, тодорхойлолт гаргаж, иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:<br>Нийгмийн даатгалын лавлагаа-600,<br>2. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагаа-296,<br>3. Иргэний оршин суугаа хаягийн тодорхойлолт-95,<br>4. Гэрлэсний бүртгэлийн лавлагаа-56,<br>5. Зээлийн мэдээллийн лавлагаа-69,<br>6. Иргэний үнэмлэхийн лавлагаа-80,<br>7. Үл хөдлөх хөрөнгөтэй эсэх-15,<br>8. Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй лавлагаа-34<br>9. Гэрлэсний бүртгэлгүй лавлагаа-11,<br>10. Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтын лавлагаа-15,<br>11. Иргэнд олгох тодорхойлолт-10,<br>12. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт-5,<br>13. Жолоочийн мэдээлэл лавлагаа 5 тус тус гаргаж ажилласан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 47. | 68. | Хурдан морины уралдааны талаар авах зарим | Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт тогтоосон хугацаанд | Бүрэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээний тухай<br>2019.01.30 дугаар57<br>1. Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний өдрөөс 5 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглосугай.<br>3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох тухай сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны А/11 дүгээр захирамж гарган шийдвэрийг хэрэгжүүлж, холбогдох хүмүүст мэдэгдэл хүргүүлж, хяналт тавьж ажилласан. Энэ хугацаанд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулагдаагүй. | хэрэгжсэн 100% | |
| 48. | 69. | **Аялал жуулчлалын гол чиглэл батлах тухай**<br>**2018.06.13 дугаар 171**<br>3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймаг, нийслэлийн аялал жуулчлалын чиглэлүүдийг аялал жуулчлалын гол чиглэлтэй нийцүүлэн баталж, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, дэд бүтцийн хөгжлийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын маршрутыг брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор байгалийн аяллын төрлөөр Найман нуур, Улаан цутгалан, Төвхөн хийд чиглэлийн маршрутыг баталж, Энэхүү маршрутаар аялагчдын тоо жил бүр нэмэгдэж байна. 2023 онд Сарлагын баярыг 14 дэх жилдээ буюу 07 дугаар сарын 23-24 нд Өндөр хясаа гэх газарт 2 өдөр зохион байгуулсан. Нийт 100 гаруй аялагчид оролцсон. Үүнээс 200 гадаад аялагч бусад дотоодын аялагч оролцсон. Улаан цутгалангийн хүрхрээний өвлийн мөсөн авиралтын тэмцээн 11 дэх жилдээ тогтмол зохион байгуулагдаж байна. | Хэрэгжих шатанд 70% | |
| 49. | 70. | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>**2018.08.22 дугаар 258**<br>1.1. Харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг зохион байгуулсан. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Засаг даргын Тамгын газар “Төрийн албаны харилцааны ур чадвар” сэдэвт сургалт 1, ЕБС “Залуу багш нарт ёс зүйн” сургалт 1, 1-р цэцэрлэг “Багшийн ёс зүй” сургалт 1, Эрүүл мэндийн төв нь “Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүй” сургалт 1, нийт 4 сургалтад 132 албан хаагч хамрагдсан. 2023 онд ажлын хариуцлага алдсан 8 | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | албан хаагчид сануулах болон цалин бууруулах арга хэмжээ тооцож ажилласан. | | |
| | 71. | 1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | Сумын ИТХ, ЗДТГазарт төрийн жинхэнэ албан тушаалын 12 орон тоо батлагдсан байдаг. ЗДТГ-т Жирэмсний болон амаржсаны амралтаа авсан төрийн жинхэнэ албан хаагчийн 1 сул орон тоонд Төрийн албаны тухай хуулийн 43.3.4 дэх заалтын дагуу төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч албан үүргийг түр орлон гүйцэтгүүлж байна. ИТХ-ын шинээр батлагдсан 2 орон тооны захиалгыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлж, тусгай шалгалт зарлагдан 2023 оны 2 дугаар сард журмын дагуу нөхөгдөн томилогдсон. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 72. | 1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсаны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | Төрийн жинхэнэ албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилоогүй. Журмыг мөрдөн ажилласан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 73. | 1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | Байгууллагын дотоод журам, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээнд сахилга хариуцлага, ёс зүйг сайжруулах заалт тусган, төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглох чиглэлээр зорилт, арга хэмжээг тусган хэрэгжүүлж, биелэлтийг тооцон ажиллаж байна. 2023 онд ийм төрлийн зөрчил гаргаж хариуцлага | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | тооцуулсан төрийн албан хаагч байхгүй. | | |
| | 74. | 1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | Төрийн жинхэнэ албан хаагч, төрийн үйлчилгээний албан хаагчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахад онцгой анхаарч сумын Засаг даргын Тамгын газар, бусад төрийн байгууллагын “Ес зүйн зөвлөл”-үүд үйл ажиллагаагаа эрчимжүүлэн ажиллаж, Шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг бүх ажилтан, албан хаагчдад танилцуулж, ёс зүйн зөрчил гаргахгүй байх баталгаа гаргуулж, дотооддоо ёс зүйн сургалтыг зохион байгуулсан. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 4 удаагийн сургалтад 132 албан хаагч хамрагдсан. 2023 онд ажлын хариуцлага алдсан 8 албан хаагчид сануулах болон цалин бууруулах арга хэмжээ тооцсон.<br>2023 оны 11 дүгээр сарын 24-нд ИТХ, ЗДТГазраас Төрийн албан хаагчдын нэг өдөр арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний үеэр “Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага” сэдэвт илтгэлийг ИТХ-ын нарийн бичгийн дарга Ж.Чимэддулам албан хаагчдад танилцуулж, албан хаагчдын иргэдтэй харилцах харьцааны ур чадварыг нэмэгдүүлсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 75. | 1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | Төрийн албан хаагчид төрийн бодлого шийдвэрийг иргэдэд хуулийн дагуу түргэн шуурхай хүргэж, ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалтгүй, ялгавартай хандах үйлдэл гаргалгүй ажиллаж байна. Энэ талаар байгууллагын дотоод журамд тусган хэрэгжүүлэн ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 76. | 3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж | 2023 оны 01 дүгээр сард Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүн сумын ЗДТГазар болон бусад байгууллагыг хамруулан хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн. Зөрчил, дутагдлыг арилгаж, цаашдынхаа ажилд мөрдлөг | Хэрэгжих | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | болгон ажилласан.<br>Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийн харилцаа хандлага, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор сумын ЗДТГ-ын эрх бүхий албан тушаалтнууд Эрүүл мэндийн төвд ажиллаж, албан хаагчдын шуурхай хурал зарлаж, зөрчил, дутагдлын талаар хугацаатай үүрэг чиглэл өгч, хяналт тавин ажилласан. | шатанд 70% | |
| 50. | 77. | **Аргачлал шинэчлэн батлах тухай**<br>**2018.01.24 дугаар 20**<br>2.Аргачлал батлагдсантай холбогдуулан хөгжлийн индекс тооцоход шаардагдах мэдээллийг дараа оны 2 дугаар сард багтаан “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д оруулан баталгаажуулж байхыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай. | Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, шаардлагатай мэдээллийг бэлдэж 2023 оны 3 дугаар сарын 02-нд “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох цахим мэдээллийн систем”-д баталгаажуулж оруулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 51. | 78. | **Журам батлах тухай**<br>**2017.07.04 Дугаар 195**<br>2. Албадлагын арга хэмжээ авсантай холбоотой хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээж, ашиглах арга хэмжээ авахыг эрх бүхий байгууллагын дарга нарт даалгасугай.<br>Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай<br>2022.06.29 дугаар 249 | Сумын Засаг даргын захирамжаар Орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, үнэлэх, худалдан борлуулах, устгалын 3 комисс ажилладаг. Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх тусгай дансыг Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээсэн. 2023 онд шийдвэрлэсэн эд зүйл байхгүй. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 52. | 79. | **Хөрс хамгаалах өдөртэй болох тухай**<br>**2017.05.24 дугаар 149**<br>1. Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийн Бямба гарагийг “Хөрс хамгаалах үндэсний өдөр” болгон тэмдэглэж байхаар тогтоосугай.<br>2. “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-ийг уул уурхай, газар тариалан, мал аж ахуйн | “Хөрс хамгаалах үндэсний өдөр”-өөр хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, газрын хөрсний бохирдлыг бууруулахад иргэн бүр анхаарч, зохион байгуулж буй арга хэмжээнд оролцохыг уриалж, энэ талаар олон нийтэд мэдээлэл хүргэсэн. Хөрсийг бохирдуулж байгаа хамгийн том хүчин зүйл нь бидний ахуй амьдралаас үүсэн гарч буй хог хаягдал байдаг. Иймд сумын Засаг даргын “Бүх | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үйлдвэрлэл эрхэлдэг болон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хөрс хамгаалах, түүнийг нөхөн сэргээх, хот, суурин газрын хөрсний бохирдлыг бууруулах, саармагжуулах талаар тухайн жилд зохион байгуулах ажил, арга хэмжээг төлөвлөж, тэдгээрийг олон нийтэд таниулан сурталчлах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран жил бүр зохион байгуулах замаар тэмдэглэн өнгөрүүлж байсугай. | нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” 2023 оны А/70 дугаар захирамжийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 26-30-ны хооронд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Нийт 240000 м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэн 1684 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгав. Хог хаягдлыг цэвэрлэх ажилд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 30,0 сая төгрөг зарцуулсан. Сэг зэмийн устгалын ажлаар нийт 13059 малын сэг, бодын сэг 4997, богын сэг 8062 цэвэрлэн тээвэрлэж, булж устгасан. | | |
| 53. | 80. | **Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай 2017.03.07 дугаар 67**<br>1. Жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх Лхагва гарагийг “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болгон зарласугай.<br>2. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, аврах үйл ажиллагаанд хүн амыг сургаж бэлтгэх, таниулах ажил зохион байгуулан жил бүр улс даяар тэмдэглэн өнгөрүүлж байсугай. | Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, таниулах өдрийг иргэдэд цахим сүлжээгээр сурталчилсан. Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх шторк, сэрэмжлүүлэг бэлтгэн сумын нэгдсэн грүпп, Бат-Өлзий-урьдчилан сэргийлэх грүпп зэргээр сурталчилсан. Шторк, сэрэмжлүүлэг цахим сүлжээгээр нийт 6000 гаруй иргэнд хүргэсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 54. | 81. | **Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2017.02.01 дугаар 46**<br>3. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаараа батлуулан хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, хяналт тавих журам батлах тухай” 2021 оны 04/02 дугаар тогтоолыг худалдаа үйлчилгээний газрууд мөрдөн ажиллаж, самбар, хуулийн буланд байршуулсан. 2023 оны 1-р улиралд 2 дэлгүүрийн тусгай зөвшөөрлийг сунгуулж, 2-р улиралд хүсэлт ирүүлсэн 18 цэгийн материалыг хүлээн авч, зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хянан баталгаажуулж, аймгийн зөвлөлд | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүүд тус тус үүрэг болгосугай. | хүргүүлж 9-р сарын 30-ний өдрийг хүртэл аймгийн Засаг даргын захирамжаар сунгасан. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан суманд архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, үйлчилгээ үзүүлж байгаа 23 иргэн, ААНэгжийн эздэд 2023 оны 11-р сарын 07-ны өдөр “Согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл авах үйлчилгээний ангилал, тавигдах шаардлага батлах тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны А/419 дүгээр тушаал, “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн тоог тогтоох тухай” Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 2023 оны А/470/А-327/А-306 дугаар тушаал, Согтууруулах ундааны хариуцлагатай үйлчилгээний сургалтын журам, архины тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай бусад мэдээллийг хүргэн сургалт зохион байгуулсан. ХХААГ-т шинэ журмын дагуу архины тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 24 цэг улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлтээ уламжилсан. | | |
| 55. | 82. | **Насны хишиг олгох журам батлах тухай**<br>**2017.01.25 дугаар 31**<br>2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан журмын дагуу ахмад настанд насны хишиг олгох ажлыг 2017 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн зохион байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг ХНХ-ын сайд Н.Номтойбаярт үүрэг болгосугай. | Насны хишгийн мөнгийг 65-69 насны 132 ахмад настанд 13.050.000 төгрөг, 70-79 насны 110 ахмад настанд 17.600.000 төгрөг, 80-89 насны 32 ахмад настанд 9.450.000 төгрөг, 90-с дээш 5 ахмад настанд 2.250.000 төгрөг. Нийт 279 ахмад настанд 42.350.000 төгрөг олгосон. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 56. | 83. | **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2016.05.02 дугаар 234**<br>2. Монголын улаан загалмай нийгэмлэгээр Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий зөвлөлийг үндэсний болон орон | 2023 онд Монголын улаан загалмайн нийгэмлэгт идэвхтэн гишүүнээр 55 иргэнийг элсүүлсэн. Монголын улаан загалмайн нийгэмлэгийн татварт 3702.0 мянган төгрөг төвлөрүүлсэн. Монголын улаан загалмайн нийгэмлэг, Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр зуданд нэрвэгдсэн 6 багийн 55 малчин өрхөд хүнс, ариун цэврийн багцийг хандивласан. Үерт өртсөн 6 багийн 40 өрхөд бэлэн мөнгө, зөөлөн эдлэл, гал тогооны иж бүрдэл | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нутгийн түвшинд байгуулан ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, аймаг, дүүргийн Засаг дарга нарт, зөвлөлийн ажиллах журмыг баталж мөрдүүлэхийг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатарт тус тус даалгасугай.<br>3. Хүмүүнлэгийн чиглэлээрх Засгийн газрын зарим чиг үүргийг Монголын улаан загалмай нийгэмлэг гүйцэтгэх болсонтой холбогдуулан тус нийгэмлэгт төсвөөс олгох санхүүжилтийг 2017 оноос эхлэн улсын болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Сангийн сайд Б.Болор, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | олгосон. | | |
| 57. | 84. | **Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай /2016-2030/**<br>**2016.01.11 дугаар 35**<br>2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улс, орон нутгийн төсөвт тусган, олон улсын байгууллага, хандивлагч орон, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 1200 иргэнд тарааж, цахимаар сурталчилсан. 2023 онд мод тарих арга хэмжээнд нийт 8 аж ауйн нэгж, 15 нөхөрлөлийн 222 иргэн оролцож 12 төрлийн 6457 ширхэг мод, бут сөөг тарьж, төлөвлөгөөг давуулан биелүүлж, ургалт 85 хувьтай. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 58. | 85. | **Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**<br>**2016.01.04 дугаар 15**<br>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай:<br>1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, суманд үйл ажиллагаа явуулж буй 7 төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, дэлгүүр, үйлчилгээний 38 газар татварын нэгдсэн системд холбогдож, төлбөрийн баримт хэвлэж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн сургалт, сурталчилгааг 3 удаа зохион байгуулж, 200-аад иргэн хамрагдаж, нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн талаарх | Хэрэгжих шатанд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хуулийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллан, татварын нэгдсэн системд холбогдох;<br>1.2. бараа, ажил, үйлчилгээг худалдан авах болон борлуулах тухай бүрт төлбөрийн баримт хэрэглэж, үүнийг хэвшүүлэх;<br>1.3. иргэд, хуулийн этгээдэд төлбөрийн баримт хэрэглэх үйл ажиллагааг хэвшүүлэх талаар нийтэд сурталчлан таниулах. | мэдлэгээ дээшлүүлсэн. | 70% | |
| 59. | 86. | **Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.12.14 дугаар 496**<br>3. Хүнсний зориулалтын бус хуванцар савыг хүнсний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн газарт хоол, хүнсний савлагаанд хэрэглэхийг хориглож, хэрэгжилтэд нь холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоодтой хамтран хяналт тавьж ажиллан, энэ тухай нийтэд мэдээлэл, сэрэмжлүүлэг түгээж, сургалт, сурталчилгаа зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ш.Раднаасэд болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. | Хуванцар савны хор нөлөө, хэрэглээг бууруулах, халах талаар 428 иргэнд мэдээлэл хүргэн мөн ган сав үйлдвэрлэгч “Чиглэл” ХХК үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг танилцуулсан. Зарын группээр видео бичлэг, шторкыг сурталчилсан. Худалдаа үйлчилгээ эрхлэгч 45 газарт хуванцар шанага худалдахгүй байх, эрүүл ахуйн шаардлага хангасан тор, савыг ашиглах талаар мэдэгдэж, зөвлөмж хүргэсэн. Ундны ус, сүү цагаан идээний сав, суулга худалдан борлуулдаг 4 дэлгүүрт хүнсний зориулалтын сав худалдан борлуулж хамтран ажиллах талаар сумын Засаг даргын албан бичиг хүргүүлсэн. Тус дэлгүүрүүд 3-100 литрийн багтаамжтай төмөр, ган, зориулалтын хуванцар сав 146 ширхэг, төмөр шанага 98 ширхэгийг иргэдэд худалдаалсан байна.<br>Суманд өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг 2-р багийн иргэн Д.Баярмөнх, 1-р багийн иргэн Э.Мөнхсайхан нар энэ онд гэрээрээ 33 андуу 21 бүрхээр, 24 саалийн хувинг үйлдвэрлэж иргэдэд нийлүүлсэн.<br>“Алтан намар 2023” үзэсгэлэн худалдааны үеэр “Зориулалтын бус хуванцар савгүй өрх айл, аж ахуйн нэгж, байгууллага болзолт уралдааныг дүгнэн 12 иргэн, 1 байгууллага, 3 дэлгүүрийг шагнаж урамшуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 60. | 87. | **Журам батлах тухай 2009.07.22 дугаар 227**<br>2. Ойн сангийн тодорхой хэсгийг энэхүү журмын дагуу нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх замаар ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой | Суманд 18 нөхөрлөл ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж байна. Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарал тавьж, Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын хүрээнд сумын | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ашиглах ажлын үр өгөөжийг дээшлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон. | хэмжээнд давхардсан тоогоор ойн 15 нөхөрлөл, 8 ААНэгж нийт 63 га талбайд 116600 ширхэг шинэсний тарьц болон бортогтой тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ойжуулалтын ажилд нийт 580 хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл улсын болон өөрийн хөрөнгө нийт 274.0 сая төгрөг зарцуулсан байна. | | |
| 61. | 88. | **Журам шинэчлэн батлах тухай**<br>**/Угийн бичиг хөтлөх журам/**<br>**2007-10-03 Дугаар 257**<br>2.Угийн бичиг хөтлөх үлгэрчилсэн загварыг 2008 онд багтаан боловсруулж хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд даалгасугай.<br>Хавсралт: 1.4.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэрийн нийт өрхийн хэмжээнд өрх бүрийг угийн бичиг хөтлүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах үүрэг хүлээнэ. | “Бат-Өлзий сумын Угийн бичиг хөтлөлт” цахим хуудас нээн ажиллуулж, цахим хуудсаар дамжуулан “Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдэвт видео сургалтыг бэлтгэн мэдээ, мэдээллийг түгээж байна. 2023 онд Хөгшин тайж Цэдэнгийн үр, хүүхдүүд ургийн уулзалтаа зохион байгуулсан. Уулзалтад 180 гаруй иргэн оролцсон. Мөн Дашдоржийн үр, сад ургийн уулзалт зохион байгуулж 214 иргэн оролцсон байна. Ургийн баяр, уулзалт хийж ном гаргасан ураг удмын судалгааг шинэчлэн гаргасан.<br>ЗДТГазар гэр бүлийн өдрөөр аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Ч.Төвхөнбаярыг урин авчирч угийн бичиг бичихийн ач тус сургалтыг зохион байгуулсан. Сургалтад ЗДТГазрын албан хаагчид түүний гэр бүлийн нийт 60 хүн хамрагдаж угийн бичгээ хөтлөөгүй албан хаагчид угийн бичгээ хөтөлж эхэлсэн. | Хэрэгжих шатанд 70% | |
| **Хэсгийн дундаж: 95,0 хувь** | | | | | |
| **Долоо. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 62. | 89. | 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл<br>2022-02-16 Дугаар 2022_11<br>2.“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх | Цахимаар авах үйлчилгээний жагсаалтыг олон нийтийн сүлжээгээр иргэдэд сурталчлан таниулж, ЗДТГ-ын цахим хуудас, Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудсаар дамжуулан хүргэж байна. E-Mongolia.mn, ehalamj.mn халамжийн нэгдсэн систем www.gazar.gov.mn, www.ndaatgal.mn, burtgel.mn-ээс цахим үйлчилгээ авах боломж бүрдсэн.<br>Сумын Засаг даргын Тамгын газарт Гэрэгэ киоскоор төрийн болон хувийн хэвшлийн үйлчилгээг цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж байна. Гэрэгэ киоскоор авто машины торгууль, татвар, жолоочийн даатгал, банк санхүүтэй холбоотой зээл, лизингийн үйлчилгээ, | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав | даатгалын үйлчилгээг хялбар авах боломжтой. Мобиком, Юнител, ЖиМобайл, Скайтелын нэгж авах, төлбөр төлөх, автобусны билет захиалах боломжтой. Түц машин буюу төрийн үйлчилгээний цахим машинтай болсон. Түц машинтай болсноор иргэд дэвшилтэт технологи ашиглан төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл боломж бүрдсэн. Мөн 2023 онд ОНХСангийн 40,0 сая төгрөгийн хөрөнгөөр ЗДТГ-ын нэг цэгийн үйлчилгээний төвд иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлсэн стандартад нийцсэн тоног төхөөрөмжтэй болсон. | | |
| 63. | 90. | 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дүгээр тэмдэглэл<br>2022-03-16 Дугаар 16<br>3.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төсөлд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төслөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав | Монгол Улсын 2023 оны төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төслөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусган хэрэгжүүлэхээр заавар, чиглэлийг баримтлан ажиллаж байна. | Хэрэгжих шатанд 70% | |
| 64. | 91. | 2021 оны 10 дугаар сарын 13-ны өдөр 55 дугаар тэмдэглэл<br>2021-10-13 Дугаар 55<br>XY.13.6.“Худалдан авах ажиллагааны цахим систем”-д худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийг худалдан авах ажиллагаа зохион байгуулдаг бүх байгууллагын удирдлагад; | “Худалдан авах ажиллагааны цахим систем”-д уламжлалт болон, цахимаар зарлагдсан худалдан авах ажиллагааны үр дүн, гэрээ, гэрээний биелэлтийг тухай бүр байршуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхээр ил тод байдлыг ханган, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 65. | 92. | 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 49 дүгээр тэмдэглэл<br>2021-08-31 Дугаар 2021_49<br>X111.5.4.Харьяалах нутаг дэвсгэр дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр холбогдох хууль | 2023 онд Төвхөн хийдийн шашин эд өлгийн зүйлийн хяналтын тооллогыг аймгийн Соёл, урлагийн газар, Өвөрхангай аймгийн Музей, сумын Соёлын төв хамтран зохион байгуулсан. Төвхөн хийдийн хосгүй үнэт өвийг хамгаалах зорилгоор улсын төсвөөс 50.0 сая төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлүүлсэн. Сумын Соёлын төвөөс | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийн хүрээнд зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдалд сар бүр хяналт тавьж, бүртгэл судалгааг тогтмол хийж байна.<br>Соёлын өвийн Үндэсний төв, аймгийн Соёл Урлагийн газар, сумын Соёлын төв хамтран 2023 оны 10 дугаар сарын 08-ны өдөр соёлын биет бус өвийн улсын үзлэг тооллогын ажлыг зохион байгуулж биет бус өвийн 6 өвлөн уламжлагчийг үндэсний мэдээллийн санд бүртгэн баримтжуулсан. | | |
| 66. | 93. | 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдөр 36 дугаар тэмдэглэл 2021-06-23 Дугаар 2021_36<br>Х11.11.3.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих замаар тухайн орон нутгаас нийлүүлэх болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжийг судалж, шийдвэрлэх чиглэлээр аймаг, нийслэлийн Засаг дарга нарт мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнийг “Өвт хайрхан” ХХК, Бат-Өлзий тревэль ХХК, Батгэгээн хангай ХХК-ууд нь өөрийн сумын мах, сүү цагаан идээ, мөн дотоодын үйлдвэрийн гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ нийлүүлж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 94. | Х11.11.4.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байргүй сургуульд шинээр зориулалтын байр барих ажлын зураг төслийг 2021 онд багтаан боловсруулж, 2022 оноос улсын төсөвт тусгуулах, төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн хоол үйлдвэрлэлийн зориулалт бүхий талбайг бусдад ашиглуулсны төлбөрөөс төвлөрүүлэх орлогыг 100 хувь тухайн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байрны засвар, тоног төхөөрөмжид зарцуулах боломжийг судлан танилцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга | ЕБСургууль нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, шаардлага хангасан зориулалтын байртай бөгөөд 2021 онд улсын төсвийн хөрөнгөөр гал тогооны тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.<br>2023 оны 4-р сарын 17-ноос үдийн хоолыг сургууль өөрсдөө хийж эхэлсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нарт; | | | |
| | 95. | Х11.12.Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:<br>1.Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар Мал эмнэлгийн байгууллагаас хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд даалгав; | 2023 онд малын гоц халварт шүлхий өвчнөөр тайван байдлыг хадгалан ажиллаж байна.<br>Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх хаврын дархлаажуулалтын ажлын хэсгиийг Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн А/74 дүгээр захирамжаар батлуулж 57,389 мянган толгой үхэр сүргийг хамруулахаар төлөвлөж гүйцэтгэлийн ажил 100 хувь хийгдсэн. Тарилгын жагсаалт, холбогдох баримтыг бүрдүүлэн цаг хугацаанд хүргүүлэн ажилласан. Тарилгын үйлчилгээний хөлсний урьдчилгаа санхүүжилт 11.477.800 төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн дансанд шилжүүлсэн.<br>Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/251 дугаар тушаалаар “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх намрын дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай” шийдвэртэй танилцаж 901 малчин өрхийн 73266 толгой үхэр сүргийг /үхэр-57217, тугал-16049/ шүлхийн вакцинд хамруулахаар төлөвлөж, гүйцэтгэл 100 хувь. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 96. | 2. Байгаль, цаг уурын хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас хорогдсон малын сэг, зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх нарийвчилсан төлөвлөгөө гарган мэргэжлийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжилтийг хангуулан 14 хоног тутам тайлан гаргаж Улсын онцгой комисст ирүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. | Бат-Өлзий сумын Засаг даргын 2023 оны 05-р сарын 09-ны өдрийн А/85 дугаар захирамжаар сэг зэм устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан өвөлжилт, хаваржилт хүндэрч малын хорогдол их гарч сумын 6 багийн хэмжээнд нийт 13059 сэг зэм (бод мал 4997, бог мал 8062)-ийг мал эмнэлгийн байгууллагын хяналтан дор халдваргүйтгэх болон устгах, булшлах үйл ажиллагааг хийж, аливаа өвчин эмгэг тархах болон байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан. Сэг зэм устгах ажилд 24 ачааны машин, 135 хүн оролцон гүйцэтгэсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 67. | 97. | 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 22 дугаар тэмдэглэл<br>2020-04-01 Дугаар 22<br>ХҮ111.2. . 2. Дараах арга хэмжээ авахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: | 2.1 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хантан ажиллаж байна. 2023 онд 43 төрлийн 1,470,325.0 мян төгрөгний төсөвт өртөг бүхий худалдан авах | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллах;<br>2.2. Худалдан авах ажиллагааны тайланг цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнах;<br>2.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчлийг арилгаж, гэрээнд заасан хугацаанд үүргийн гүйцэтгэлийг хангаж, гэрээний үүргээ зөрчсөн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг тус хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу нотлох баримтын хамт тухай бүр Сангийн яаманд хүргүүлэх;<br>2.4.Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавихгүй байх, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулах. | ажиллагаа зохион байгуулагдах төлөвлөгөөнөөс 43 төрлийн 1,171.2 сая төгрөгний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Үүнд: нээлттэй тендер 3, ТШОЖ буюу Харьцуулалтын аргаар 8, шууд худалдан авах ажиллагааны аргаар 30 ажлын худалдан авалтыг тус тус зохион байгуулсан.<br>2.2 Худалдан авах ажиллагааны тайланг тухай бүр цахим системд нийтэлж, бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр бүрээр бүрэн тайлагнаж ажилласан.<br>2.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасны дагуу хүчинтэй байх хугацаанд, хуульд заасан шаардлагын дагуу шалгарсан оролцогчоос ирүүлсэн гүйцэтгэлийн баталгааг үндэслэн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, гэрээний гүйцэтгэлийн явцад гарсан аливаа зөрчил гараагүй.<br>2.4.Тендерийн баримт бичгийг боловсруулахдаа захиалагч бусдад давуу байдал олгох, бодит шаардлагаас хэтрүүлэн өндөр эсхүл тухайн бараа, ажил, үйлчилгээний эцсийн үр дүн, гүйцэтгэлд шууд хамаарахгүй шалгуур үзүүлэлтийг тавиагүй, тендерийн шалгуур үзүүлэлтийг чанар, эцсийн үр дүнд үндэслэн боловсруулсан. Хүнсний бараа худалдан авах ажиллагаанд орон нутагт үйлдвэрлэсэн мах, сүү цагаан идээ, талх, боорцог, ажил гүйцэтгэх худалдан авах ажиллагаанд орон нутгийн ажиллах хүчинд давуу байдал олгох байдлаар худалдан авах ажиллагааг зохион байгуулан ажилласан. | | |
| **Хэсгийн дундаж: 96,6 хувь** | | | | | |
| **Найм. Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 68. | 98. | Тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2020-11-19 дугаар 2<br>1.Дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг | Суманд төрийн үйлчилгээний нэгдсэн системээс лавлагаа, мэдээлэл гаргах эрх бүхий “Оператор” ажиллаж байна. Оператор нь 2023 оны 5-р сард E-mongolia операторын танхимын 1 өдрийн сургалтад хамрагдаж, иргэдэд лавлагаа, мэдээллийг саадгүй гарган ажиллаж | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дарга нарт:<br>1.3.Төрийн үйлчилгээг нэгдсэн системээр дамжуулан үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах, үйлчилгээний ажилтнуудыг сургаж, бэлтгэх; | байна. | | |
| | 99. | 1.4.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарч буй аливаа лавлагаа тодорхойлолтыг шалган баталгаажуулж байх, холбогдох мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтад хүргүүлж, харилцан солилцож байх; | Бат-Өлзий сумын ИТХ, ЗДТГазар болон төрийн байгууллагууд нь ХУР систем, киоск машинаас авсан лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн төрийн үйлчилгээг шуурхай хүргэн, байгууллага хооронд харилцан солилцон ашиглаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 100. | 1.5.Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж, төрийн үйлчилгээнд тоон гарын үсэг нэвтрүүлэх арга хэмжээ авах; | Тоон гарын үсгийн гэрчилгээг 1503 иргэнд олгосон. Төрийн үйлчилгээнд цахим гарын үсгийг нэвтрүүлэн төрийн сангийн гүйлгээ, төлбөр, тооцоо, лавлаа, мэдээлэл, гэрээ хэлцэлд ашиглаж байна. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 101. | 1.8.Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар цахим хуудас, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчлах; | Цахимаар үзүүлж буй төрийн үйлчилгээний талаар Бат-Өлзий сумын нэгдсэн групп, Бат-Өлзий сумын Хууль, эрх зүйн хөтөч пэйж хуудас, эрх зүйн хөтчийн булан, олон нийтийн бусад сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон шаардлагатай бусад хэлбэрээр мэдээлэл түгээж, нийтэд сурталчилж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 102. | 1.9.Албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийг “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбож, албан бичгийг байгууллага хооронд цахимаар солилцох. | “Төрийн албан бичиг солилцооны нэгдсэн систем”-д холбох ажлыг эхлүүлсэн. Албан бичгийг байгууллага хооронд солилцохдоо байгууллага, албан хаагчийн албаны мэйл хаягийг ашиглан хүлээн авч, шилжүүлж байна. | Хэрэгжих шатанд 70% | |
| **Хэсгийн дундаж: 88 хувь** | | | | | |
| **Ес. Сайдын тушаал** | | | | | |
| | 103. | **Журам батлах тухай**<br>**2023.09.13 дугаар а/450**<br>1."Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам"-ыг хавсралт ёсоор батлагсугай.<br>2.Энэхүү журмыг захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар (Ц.Уранчимэг)-т, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тусгай | Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын “Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох тухай” 2023 оны 09 сарын 25-ны өдрийн А/518 дугаар тушаалаар Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд 822,819 кг самрыг үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх шийдвэр гарсан. Тухайн шийдвэрийг үндэслэн Бат-Өлзий сумын Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн А/123 дугаар захирамжаар хуш модны самрыг бэлтгэх тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдаа зохион байгуулах | Бүрэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хамгаалалттай бүс нутгийн бодлого зохицуулалтын газар (Н.Баатарцогт)-т, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар (Б.Оюунсанаа)-т, Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. | чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулж, үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх хуш модны самрын багцын хуваарийг гаргасан. Үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх, тээвэрлэх хуш модны самрын тусгай зөвшөөрлийг олгох дуудлага худалдааг 2023 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 11 цагт цахимаар хууль, журамд нийцүүлэн зохион байгуулж, дуудлага худалдаанд нийт 14 багц дээр 17 ААНэгж оролцож, дуудлага худалдаанд 9 ААНэгж ялалт байгуулж, орон нутгийн төсөвт 866,346,600 төгрөг оруулсан. Хуш модны самрын дүгнэлт гаргах, хяналт шалгалтын шатахууны зардалд 2,450,000 төгрөг зарцуулсан. | хэрэгжсэн 100% | |
| | 104. | **Журам батлах тухай (**тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам**)**<br>**2022.07.06 Дугаар** А/218/А/146<br>2. Журмын хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам (Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Санхүү, хөрөнгө оруулалтын газар), аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн нэгжид тус тус даалгасугай. | Орон нутгийн хөгжлийн сангийн 82,0 сая төгрөгөөр HONWA-804 маркийн 80 морины хүчин чадалтай тракторыг дагалдах эд анги анжис, борной, төмс үрлэгчийн хамт худалдан авч, газар тариалан эрхлэгч Б.Хэнчбишд гэрээгээр эзэмшүүлсэн. 2 иргэн жимс, жимсгэний тариалалт 1.4 га-аар нэмэгдүүлж 1150 суулгац шинээр суулган тариалсан. Сумын тариалан эрхлэгч 18 иргэнд 9 нэр төрлийн хүнсний ногооны үр, зорилтот жилийн хүрээнд шинээр хашаандаа төмс, хүнсний ногоо тарих гэж байгаа 26 иргэнд 9 нэр төрлийн хүнсний ногоо, 300 кг төмсний үрийг хөнгөлөлттэй үнийн дэмжлэг үзүүлэн хүнсний хангамжийг нэмэгдүүлэн ажилласан. 0,8 га газарт 9 нэр төрлийн төмс, хүнсний ногоог шинээр тариалуулахаар нийт 26 өрхөд хөнгөлттэй үнээр дэмжлэг үзүүлэн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн. ХХААГазраас зорилтот жилийн хүрээнд 6*8 хэмжээтэй 2 хүлэмжийг тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 5-р багийн иргэн Ч.Мягмарсүрэн, 2-р баг А.Батсүх ахлагчтай бүлд эргэн төлөгдөх нөхцөлгүй хүлээлгэн өгсөн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 105. | **Журам батлах тухай (**Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам**)**<br>**2022.02.22 дугаар а/59** | Дотуур байр, үдийн хоолны гал тогоо нь эрүүл ахуйн шаардлагат нийцсэн, хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр хангагдсан байранд үйл ажиллагаагаа явуулж байна.<br>Үдийн хоолны хүнс, дотуур байрын хүүхдийн хүнс | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 3. Журмыг хэрэгжүүлэхэд сургалтын байгууллагад арга зүйн дэмжлэг үзүүлэх, тайланг жил бүрийн 07 дугаар сарын 01-ний дотор Боловсролын ерөнхий газарт ирүүлэхийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт, нийслэлийн Боловсролын газарт, журмын хэрэгжилтийг олон нийтэд ил тод, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай. | нийлүүлэгч нь зориулалтын хүнсний скаладтай, сурагчдад олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн нь мэргэжлийн хяналтын албаны дүгнэлттэй байдаг ба бүтээгдэхүүнээ өдөр бүр шинээр хийж байгаа нь чанарт сайнаар нөлөөлдөг. Үдийн хоол хөтөлбөрийн хяналтын зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй. Хяналтын зөвлөлийн гишүүд нь 14 хоног бүр үдийн хоолны газрын ажлын байр орчны эрүүл ахуй хүнсний бүтээгдэхүүний хадгалалт ажиллагсад болон бүтээгдэхүүний эрүүл ахуйн шинжилгээ хийлгэсэн эсэхэд хяналт тавьдаг. Мөн сургуулийн эмч нийлүүлэгдэж буй хүнсний бүтээгдэхүүний дээжийг журмын дагуу авч, дээж устгалын дэвтэр хөтлөн устгадаг. Бага ангийн сургалтын менежер, анги удирдсан багш нар өдөр бүрийн үдийн хоолны амт чанар, орц хэмжээ, эрүүл ахуйд хяналт тавин ажиллаж хэвшсэн.<br>"Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны жор технологи" гарын авлагыг ахлах тогооч мөрдөж ажиллаж байна. Үдийн хоол хөтөлбөрт 883 сурагч хамрагддаг. Үдийн хоолны газарт ажиллагсад журмын дагуу эрүүл мэндийн шинжилгээнд хамрагдсан мэргэжлийн 4 тогооч ажилладаг. Хоол зүйч ажиллуулахаар ажлын байр зарласан.<br>Сурагчдын нас, бие бялдрын онцлог, илчлэг хэрэгцээнд тохирсон чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан үдийн цайны цэс зохиож Өвөрхангай аймгийн Дэлгэрэх хүнс, сумын талхны Есөн бэйкэри зэрэг үйлдвэрүүдээс боорцог, талхаа мөн суманд тариалсан чацаргана, төмс, хүнсний ногоогоо, мөн малчдын гар дээрээс махаа нийлүүлэхээр нийлүүлэгч Өвтхайрхан ХХК, Бат-Өлзийт трейвел ХХК-нууд гэрээгээ байгуулан нийлүүлж байна. Эцэг эх болон, багш, ажилчдаас санал авах дэвтэр, саналын хайрцаг ажиллуулдаг. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 69. | 106. | Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам<br>2021.05.24 дугаар 86<br>1.“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл | Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны шинэчилсэн журмыг хяналтад авч, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд оролцдог бүх шатны албан хаагчдад танилцуулан ажилласан. Тус журмаар 2-3 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | ажиллагааны журам”-ыг хавсралтаар шинэчлэн батлалсугай.<br>2.Батлагдсан журмыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлж, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд мөрдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төрийн сангийн газар /М.Батхуяг/-т тус тус үүрэг болгосугай. | удаа сургалт зохион байгуулсан. Сумын төсвийн ил тод байдлыг хангах үүднээс Санхүүгийн албанаас “Бат-Өлзий сумын санхүүгийн алба” facebook – page хуудас нээж төсвийн төлөвлөгөө, гүйцэтглийн мэдээллийг тухай бүр мэдээлж байна. Орон нутгийн хөгжлийн сан, “Худалдан авах ажиллагаа” чат групп нээж, үүнд шинэчилсэн дүрэм, журам, заавар, зөвлөгөөг тогтмол өгч хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>2023 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээс 847,0 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараас 178.0 сая төгрөг буюу нийт 1,024,9 сая төгрөгний 28 хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулснаас 22 төрлийн 731.8 сая төгрөгний ажил хэрэгжиж байна. Үүнээс: Нээлттэй тендер 3 ажил буюу 364.2 сая төгрөг, ТШОЖ-Харьцуулалтын аргаар 3 ажил 188,6 сая төгрөг, шууд худалдан авалтын аргаар 15 буюу 127.8 сая төгрөгний хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүн, мэдээллийг цахим хуудсанд байршуулсан.<br>(Үүнд: Рамын дэнж, наймаа буланд үерийн далантай болох 162.2 сая, Зөрүүлэг багийн төвийн урд голд гүүр барих 120,0 сая, ХАА, газар тариаланд шаардлагатай трактор худалдан авах 82.0 сая, Иргэдэд төрийн үйлчилгээг багцаар нь хүргэх боломжийг бүрдүүлэх стандартад нийцсэн тоног төхөөрөмж авах 40.0 сая, Сумын төвд цамхагт гэрэл болон бусад гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, гэрэлтүүлэг засвар 79.0 сая, Хүнсний зоорь 50 хувь, Ерөнхий боловсролын сургуулийн заал засвар үлдэгдэл санхүүжилт 60.0 сая, Рамын дэнж, наймаа буланд үерийн далантай болох ажил эхлүүлэх нийт төсөвт өртөг /1.2 тэр бум/ -голын гольдрол өөрчлөх - 3,0 сая, Бугатын зам засах 20.0 сая, Хөнөгийн голын гүүр /засах/ 20.0 сая, Сумын төвийн золбин муур, нохой устгах | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 7.0 сая, Өвтийн даваа засах /Улаан хад, Өвтийн даваа/ 2.9 сая, Багийн зам завсар 2022 оны үлдэгдэл санхүүжилт 10.0 сая, Бүрэгтий багийн худагнууд засвар 8.0 сая, Малчдад зориулсан сургалт сурталчилгааны зардал 10.2 сая, Урд-Агуйтын амны худаг засвар 2.0 сая, Төмөрт хужиртын худаг засвар 5.0 сая, Малын чанар сайжруулахад зориулагдсан малыг ялган ангилах тоног төхөөрөмжтэй болох 4.9 сая, Ногоон тэжээл тарих 3.0 сая, Цехийн хороонд Цамхагт гэрэлтүүлэгтэй болох, ЗДТГ-ын туузан гэрэл 18.0 сая, Сумын төвийн гэрэлтүүлэг засварын ажил 8.0 сая, Гамшгаас хамгаалах зардал 14.5 сая, Ерөнхий боловсролын сургуулийн заалны шал засвар үлдэгдэл санхүүжилт 20.0 сая, Ерөнхий боловсролын сургуулийн заалны цонх засвар үлдэгдэл санхүүжилт 9.8 сая, Урд-Агуйт, Цагаан гол, Намагийн булагийн эх хаших 12.0 сая,<br>Сумын төвд малын тарилгын хашаа барих 2.0 сая) | | |
| 70. | 107. | Журам шинэчлэн батлах тухай<br>2021.04.20 дугаар 61<br>1. “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг хавсралтаар шинэчлэн батлсугай.<br>2. Шинэчлэн баталсан журмыг мөрдөж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгосугай. | Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын шинэчилсэн журмыг мөрдөж, 2023 онд Засаг даргын нөөцөд 25.0 сая төгрөг төсөвлөж, сумын Засаг даргын шийдвэрээр Засаг даргын нөөц сангаас 25,0 сая төгрөг зарцуулсан. Засаг даргын нөөц сангаас сэг зэм устгах, Өвөрхангай аймгаас тэжээл татах, Цэргийн тоо бүртгэл, аймаг, сумын аварга малчдад хүндэтгэл үзүүлэх, ээлжит цэрэг татлага, Мал мах нэгдсэн арга хэмжээ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний сургалт зэрэг зардалд тус тус зарцуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 71. | 108. | **Бугын эвэр түүж бэлтгэхийг түр хугацаагаар хориглох тухай**<br>**2017.04.20 дугаар А/97**<br>2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж, орон нутагт холбогдох арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, Аймаг нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, Тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга, Сав газрын | Ой, хээрийн түймэр, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ой, ойт хээрийн бүсэд байгалийн жамаар унасан бугын ясан эвэр түүх үйл ажиллагааг хориглсон тухай мэдээллийг иргэд, олон нийтэд цахимаар өгсөн. Сурталчилгаанд 1500 гаруй иргэн хамрагдаж мэдээлэлтэй болсон. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | захиргааны дарга, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газар /Ч.Батсансар/-т тус тус даалгасугай. | | | |
| **Хэсгийн дундаж: 100 хувь** | | | | | |
| **Арав. Сайдын албан даалгавар** | | | | | |
| 72. | 109. | **Монголд Зочлох жил болгон зарласантай холбогдуулан "Эрүүл аюулгүй-Цэвэр орчин" бүрдүүлэх арга хэмжээний тухай**<br>**2023.02.28 дугаар 02**<br>**1.1.** Хаврын улирал эхэлсэнтэй холбогдуулан шар усны үерээс хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд гэр хорооллын бүсийн гудамж талбай, усан сан бүхий газрын эрүүл ахуйн хамгаалалтын бүсэд болон автозамын дагуух хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулж, бүх нийтийн цэвэрлэгээг сар тутам зохион байгуулах | Сумын Засаг даргын "Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай" 2023 оны А/70 дугаар захирамжийн дагуу 2023 оны 04 дүгээр сарын 26-30-ны хооронд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Нийт 240000 м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэн 1684 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгав. Сэг зэмийн устгалын ажлаар нийт 13059 малын сэг, бодын сэг 4997, богын сэг 8062 цэвэрлэн тээвэрлэж, булж устгасан.<br>Сумын Цагдаагийн тасгаас санаачлан булаг шандын эхийг цэвэрлэх челленж үүсгэн иргэд, албан байгууллагуудыг татан оролцуулж хог хаягдлыг цэвэрлэсэн. Мөн ЕБС-ийн ахлах ангийн сурагчдаар гол горхи, булаг, усан сан бүхий газрын орчны хог хаягдлыг цэвэрлүүлсэн.<br>Аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газарт явуулсан "Сэг зэм устгах, гол горхины голдирол, үерийн далан, суваг, шуудууг цэвэрлэх" төсөл дэмжигдэж, Төслийн хүрээнд 30 иргэнийг өдрийн 40,000 төгрөгөөр 2023.05.06-2023.05.15-ны өдрийг дуустал 10 хоногийн хугацаатай ажиллуулж хог хаягдлыг бүрэн цэвэрлэсэн.<br>Хавар, намрын их цэвэрлэгээг хийж, аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан, хог хаягдлыг бууруулах, 3-р зэрэглэлийн стандартад нийцүүлэх ажиллаж ковш машинтай болж хогийн цэгийн тайлбайн хогийг хумих ажлыг улирал тутам гүйцэтгэсэн. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 110. | 1.2. 0рон нутагт эвент арга хэмжээ зохион байгуулахдаа талбайгаас 500 м-ээс доошгүй зайд автомашины зогсоолын талбай, энгийн хог | 2023 онд зохион байгуулагдсан олон нийтийг хамарсан баяр наадмын үеэр төв талбайгаас 500 м-ээс доошгүй зайд автомашины зогсоолын талбай, энгийн хог хаягдлыг | Хэрэгжих шатанд 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хог хаягдлын цэг, байгаль орчинд ээлтэй ариун цэврийн байгууламжийг байрлуулж тэмдэгжүүлсэн байх; | эх үүсвэр дээр нь ангилан ялгах хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламжийг байрлуулж ажилласан. | | |
| | 111. | 1.3. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, үүсгэгч нь хариуцах, санхүүжилт, урамшууллын шинэ системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх; | Ангилан ялгах хогийн савыг нийтийн эдэлбэрийн 6 газарт шинээр байршуулсан. Албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд үйл ажиллагаа явуулж буй цэгүүдэд байршуулсан. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 112. | 1.4. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар уриалах болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг бууруулах, нүхэн жорлонг ашиглалтаас хасах, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахимаар тогтмол сурталчлах; | Иргэд олон нийтэд болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад багаас нь зөв зан үйлийг төлөвшүүлэх, нөлөөлөх зорилгоор ЕБС-ийн сурагчдад Байгаль орчны чиглэлээр мэргэжил эзэмшихэд судлах шаардлагатай хичээл, тухайн мэргэжил эзэмшихийн давуу тал зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгч, байгаль орчин, танин мэдэхүйн сэдвээр А.Х.А зохион байгуулан шалгарсан сурагчдад үнэ бүхий зүйлээр шагнаж урамшууллаа. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, өдөр бүр тогтсон цэгт хаях, хог хаягдал шатаах, автомашин ил задгай угаах, гудамж талбайд нус, шүлс, цэр, тамхины иш хаяхгүй байх, орчны бохирдлоос урьдчилан сэргийлэх талаар цахимаар тогтмол мэдээллийг түгээн ажилласан. Орчны бохирдол, хог хаягдлыг бууруулахад иргэдийн оролцоо сэдвээр багийн иргэдийн нийтийн хурлаар 780 гаруй иргэнд мэдээлэл хүргэсэн. Хүрхээ орчинд аялагч хүлээн авч буй айл өрхүүд нийлж нүхэн жорлонг ашиглалтаас гаргаж 20тн-ны контенер ашиглан аялагчдын ариун цэврийн байгууламжийг сайжруулсан. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 113. | 1.5. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаанд хяналт тавих, нутаг дэвсгэрийн хэмжээнд хадгалагдаж байгаа аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх; | Эрүүл мэндийн төв аюултай хог хаягдлын бүртгэлийг тогтмол хөтлөн бүртгэлийг хийж хэвшсэн. 2023 онд 1,08 тн аюултай хог хаягдлыг устгах үйл ажиллагааг ЭМТөв, Засаг даргын Тамгын газар хамтран зохион байгуулсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 114. | 1.6. Аймаг, сумын хог хаягдлын цэгийг хумих, цэгцлэх, булшлах арга хэмжээ авах; | Сумын Засаг даргын Тамгын газар, Бат-Өлзий тохижилт үйлчилгээ УТҮГазартай хамтран 2023 онд хогийн нэгдсэн | Хэрэгжих шатанд | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | цэгийн хогийг 4 удаа хумих ажлыг гүйцэтгэсэн. Орон нутгийн хөгжлийн сангийн 30,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын төвийн дээд хогийн цэгийн талбайн хэмжээг хумих, түрэх, отволдох, цэвэрлэх ажлыг хамтран гүйцэтгэв.<br>Хог хаягдлыг бууруулах, 3-р зэрэглэлийн стандартад нийцүүлэн ажиллахаар ковш машинтай болж хогийн цэгийн тайлбайн хогийг хумих ажлыг улирал тутам гүйцэтгэж байна. | 70% | |
| | 115. | **2.2.** 0лон улсын, улсын болон орон нутгийн чанартай автозамын дагуух үйлчилгээний цэгүүдийн нүхэн жорлонг ашиглалтаас гарган буулгаж, хөрсийг нөхөн сэргээх арга хэмжээ авч, Нийтийн ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага MNS 4943:2011 стандартын шаардлага хангасан нийтийн ариун цэврийн байгууламжтай болгох; | Аялал жуулчлалын бүс нутаг, автозам болон голын голидрол дагуух нүхэн нойлыг буулгах ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 28-ны А/98 дугаар захирамжаар байгуулсан. Энэ ажлын хүрээнд 12 аялал жуулчлалын бааз, 65 иргэнд мэдэгдэл хүргүүлэн, 60 хувьтай нүхэн нойлыг буулгуулсан. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 116. | 2.3. Хөрсний бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх хүрээнд гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний тооллого зохион байгуулж, Гэр хорооллын нүхэн жорлонд тавигдах Техникийн шаардлага MNS 5924:2019 шаардлага хангуулж, хөрсний бохирдлоос урьдчилан сэргийлж эко жорлонтой болгох арга хэмжээ авах; | Гэр хорооллын айл өрхийн нүхэн жорлон, угаадасны нүхний урьдчилсан судалгааг гаргасан.<br>Цаашид шинэ сум төслийн хүрээнд хийгдэж буй ажил дуусахаар холбогдох айл өрх, албан байгууллагууд стандартын дагуу байгууламжуудыг холбож эхэлнэ. | Хэрэгжил т хангалтгү й 30% | |
| | 117. | 2.7. Аялал жуулчлалын баазуудын нүхэн жорлонг буулгаж MNS 5924:2019 стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох; | Суманд үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын 12 бааз нүхэн жорлонгоо буулгасан. Сумын ЗДТГ, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар болон Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай хамтран аялал жуулчлал эрхлэгч бааз болон иргэдэд хугацаатай шаардлага өгч, баазуудын 60 хувь нь стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болсон. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 118. | 3.1. Аймаг, сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудын гадна орчны их цэвэрлэгээг тогтмол хийх ажил | Албан байгууллага, аж ахуйн нэгжүүд ойр орчны 50 метр талбайн хог, хаягдлыг тогтмол цэвэрлэж, эрүүл аюулгүй цэвэр орчин бий болгон ажилласан. | Бүрэн хэрэгжсэн | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | өрнүүлж, эрүүл аюулгүй, цэвэр орчин бий болгох; | | 100% | |
| | 119. | 3.2. Зүй бусаар болон байгалийн гамшгийн улмаас хорогдсон мал, амьтны сэг, зэмийг мал эмнэлгийн байгууллагын хяналтан доор халдваргүйтгэх болон устгах, булшлах үйл ажиллагааг зохион байгуулж, аливаа өвчин эмгэг тархах болон байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах; | Бат-Өлзий сумын Засаг даргын 2023 оны 05-р сарын 09-ны өдрийн А/85 дугаар захирамжаар сэг зэм устгах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан өвөлжилт, хаваржилт хүндэрч малын хорогдол их гарч сумын 6 багийн хэмжээнд нийт 13059 сэг зэм (бод мал 4997, бог мал 8062)-ийг мал эмнэлгийн байгууллагын хяналтан доор халдваргүйтгэх болон устгах, булшлах үйл ажиллагааг хийж, аливаа өвчин эмгэг тархах болон байгаль орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсан. Сэг зэм устгах ажилд 24 ачааны машин, 135 хүн оролцон гүйцэтгэсэн. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 120. | 3.3. Аялал жуулчлалын бүс нутаг дахь уул овооны хог хаягдлыг тогтмол цэвэрлэх; | Бат-Өлзий сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8а ангийн сурагчид, АА сайн дурын бүлэг, нутгийн иргэд “Цагаан хайрхан”-ны ойр орчны хог хаягдлыг цэвэрлэж хэвшсэн. Мөн энэ жил Төвхөн хийдийн ойр, орчны хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, ариун цэврийн байгууламжийг сайжруулсан. | Хэрэгжих шатанд 70% | |
| | 121. | 3.4. Тохижилт үйлчилгээний компаниудын ажлыг эрчимжүүлж зам дагуух хашлага хайс болон бусад нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулах; | Бат-Өлзий тохижилт үйлчилгээ улсын өмчит үйлдвэрийн газар нь нийтийн эзэмшлийн зам, хайсыг хамгаалж, талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сар бүр зохион байгуулж ажилласан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| 73. | 122. | **Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай**<br>**2015.01.25 дугаар 01**<br>Хоёр. Сум, дүүргийн Засаг дарга нарт, аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газруудад:<br>1. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, хяналт, шалгалтын ажлыг тогтмол зохион байгуулах. | Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хяналт, шалгалт зохион байгуулж, байгаль орчны чиглэлээр гомдол мэдээллийн дугаар 15 удаа, зөрчлийн хэргийн дугаар 9 удаа авч бүртгэлд оруулан 100 хувь шийдвэрлэсэн. Иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хуулийн сурталчилгаа, зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч ажилласан. Сурталчилгаанд 700 гаруй иргэн хамрагдсан. ЗДТГ-ын Хууль, эрх зүйн мэргэжилтэн Г.Доржханд хууль бус мод бэлтгэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль сурталчилсан шторк бэлтгэн сумын иргэдэд сурталчилсан. Хуулийн шторкийг | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | 2200 иргэн үзэж мэдээлэл авсан. | | |
| | 123. | 2. Сумын төвүүдэд мод, модон материалын төвлөрсөн захыг нээж, ажиллуулах, модны захыг бичлэг хийх боломжтой камераар тоноглож, өөр аймаг, сум руу тээвэрлэгдэж байгаа мод, модон материалыг зөвхөн энэ модны захаас гаргадаг нөхцөлийг бүрдүүлж ажиллах, ингэснээр мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээг нэг цэгээс олгох үйлчилгээг нэвтрүүлэх. | Модны захын эзэнтэй экологийн хариуцлагын гэрээ байгуулж, мод, модон материал боловсруулах цэгүүдийг камержуулсан. Модны зах дээр бүх нөхөрлөлүүдийн бэлтгэсэн хэрэглээ болон түлээний модыг төвлөрүүлж гарал үүслийн гэрчилгээг олгож, мод, модон материал тээвэрлэх гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж ажилласан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 124. | 3. Хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх чиглэлээр сайн дурын бүлэг байгуулж ажиллуулах асуудлыг дэмжих, хууль бус мод бэлтгэлтэй тэмцэх ажилд иргэн, нөхөрлөл, ТББ-ын оролцоог нэмэгдүүлэх | Бат-Өлзий сумын Ойн анги, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Байгаль хамгаалагч нар хамтран хяналт шалгалтын ажлыг хамтран зохион байгуулж, оролцоог нэмэгдүүлж байна. Ойн мэргэжлийн байгууллага 8, 15 нөхөрлөлийн ахлагч нартай Хууль бус мод бэлтгэх, зөрчлийг бууруулах чиглэлээр баталгаа гаргуулан авч, хамтран ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 125. | 4. Ойн санг нөхөрлөл, ААН, байгууллагад гэрээгээр эзэмшүүлэх талбайн хэмжээг нэмэгдүүлэх, ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН, байгууллагын ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах. | Ойн сангийн 40 хувийг нөхөрлөл, ААН, байгууллагад гэрээгээр эзэмшүүлж, ойн санг гэрээгээр эзэмшиж байгаа нөхөрлөл, ААН, байгууллагуудын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавин, Ойн санг гэрээгээр эзэмших, орчны бүс болон нийт талбайг хариуцан хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах чиглэлээр ажиллаж, Нөхөрлөлүүдийг чадваржуулах, бэхжүүлэх, ойг нөхөн сэргээж, хамгаалах ажлыг сайжруулах тал дээр анхаарч, ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын үр дүнг сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөөг байнга өгч ажиллаж байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 126. | 5. Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар Зарлигийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг ойн мэргэжлийн байгууллага, төрийн байгууллага, нөхөрлөл, иргэдтэй хамтарч зохион байгуулан мэдээллийг ил тод болгох арга хэмжээ авах. | Ерөнхийлөгчийн 2014 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 48 дугаар Зарлигийг сурталчлах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд 8 аж ахуйн нэгжийн захирал, 8 нөхөрлөлийн ахлагч нартай хууль бус мод бэлтгэлтэй эрчимтэй тэмцэх баталгаа гаргуулж авсан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| | 127. | 6. ААН, байгууллагын бэлтгэх болон бэлтгэсэн модны хэмжээг ил тод болгох. | Мод бэлтгэлийн мэдээллийг ил тод болгон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон цахим хуудас, мэдээллийн самбарт нээлттэй мэдээлж ажилласан. | Бүрэн хэрэгжсэн 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 128. | 7. Мод бэлтгэсэн ААН, нөхөрлөлийн өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийсэн байдлыг шалгах, хийгээгүй тохиолдолд нөхөн тариулах, шаардлагатай бол мэргэжлийн байгууллагын эрхийг цуцлах арга хэмжээ авах. | Ойг нөхөн сэргээх, ойжуулах ажлын хүрээнд сумын хэмжээнд давхардсан тоогоор ойн 15 нөхөрлөл, 8 ААНэгж нийт 63 га талбайд 116600 ширхэг шинэсний тарьц болон бортогтой тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Ойжуулалтын ажилд нийт 580 хүн оролцсон. Ойжуулалтын зардалд аж ахуйн нэгж, ойн нөхөрлөл улсын болон өөрийн хөрөнгө нийт 274.0 сая төгрөг зарцуулсан байна. | Бүрэн хэрэгжсэн 100% | |
| **Хэсгийн дундаж: 84,5 хувь** | | | | | |
| **ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ: 93,3 хувь** | | | | | |

БАТАЛГААЖУУЛСАН:
ЗАСАГ ДАРГА С.АМГАЛАН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗДТГ-ЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Г.ДОРЖХАНД